

АЛСЫН ХАРАА

2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

АМЬДРАЛЫН ЧАНАР БА
ДУНДАЖ ДАВХАРГА

3

ᠠᠯᠤᠰᠢᠨ ᠬᠠᠷᠠᠭ᠎ᠠ
ᠲᠣᠮᠤᠮᠤᠯᠤᠯ

ᠠᠮᠢᠶᠳᠤᠷᠠᠯᠠᠭ ᠴᠢᠨᠠᠷ ᠪᠠ
ᠳᠤᠨᠳᠠᠵᠢᠨ ᠳᠠᠪᠬᠠᠷᠭ᠎ᠠ



АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО



АМЬДРАЛЫН ЧАНАР БА
ДУНДАЖ ДАВХАРГА

3

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий хөрөнгө оруулалтын таатай орчин нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ.



АЛСЫН ХАРАА
2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Ерөнхий редактор:

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН
Баянгэрэлийн БАТБААТАР

Редакцын баг:

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН
Өлзийбүрэнгийн ЖАМЪЯН
Вандангийн БАТЦЭЦЭГ
Цэдэнбалын ЭНХЦЭЦЭГ

Зөвлөх:

Аюушийн АРИУНЗАЯА
Цогтсайханы БОЛОРМАА
Жигжидсүрэнгийн БЯМБАСҮРЭН
Шаравын МӨНХЦЭРЭН

Туслан гүйцэтгэсэн:

Галбадрахын БИЛГҮҮН
Батцэнгэлийн ҮҮРЦАЙХ

Дизайнер:

Нямжавын БЯМБАЦОГТ
Жаргалсайханы МӨНХСАЙХАН

Гэрэл зураг:

МРА.МН
Жамбалын БАТБААТАР /БАКУ/
Хишигтогтохын ТҮШИГ

Хавтасны зураг:

Багбаатарын ЦОЛМОНБАЯР

Улаанбаатар хот 2022 он

Copyright © ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан болно. Бүтээлийг ашгийн бус зорилгоор олон нийтэд түгээх, хуваалцах, ашиглах, хэрэглэх эрхтэй бөгөөд гагцхүү эх сурвалжийг дурдана уу.

Хэвлэлийн эхийг Нэпко хэвлэлийн газарт бэлтгэж,
"Мөнхийн үсэг" ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN: 978-9919-511-63-0



ГАРЧИГ

ДУНДАЖ ДАВХАРГА ЗОНХИЛСОН НИЙГЭМ	8
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ БА ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ	14
ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН БАЙР	24
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ГАРААНЫ БИЗНЕС	34
ДУНДАЖ ДАВХАРГЫГ ДЭМЖСЭН САНХҮҮЖИЛТ	44
ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ	50
ГАЗРЫН ХАРИЛЦАА	58

АМЬДРАЛЫН ЧАНАР ХАНГАГДСАН ДУНДАЖ ДАВХАРГА

Аливаа улсын нийгмийн хөгжлийн бодлогын зорилго нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар хүн амынхаа орлогыг нэмэгдүүлэн амьдралын чанарыг дээшлүүлэх буюу иргэдээ бүх талаар хөгжүүлж, тав тухтай, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр хангахад чиглэсэн байдаг.


Монгол Улсын 1992 онд баталсан Үндсэн хуулиар бид улс орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулна гэж тунхагласан нь дундаж давхарга зонхилсон нийгэм байгуулах үндсэн суурь болно.

2020 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 27.8 хувь нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй байна. Нийт хүн амын 61.3 хувь хөдөлмөрийн насныхан буюу хүн амын цонх үе нээгдсэн ч тэдний 52.3 хувь нь л хөдөлмөр эрхэлж байна.

Нийгмийн хөдөлгөгч хүч болсон дундаж давхарга эмзэг нимгэн байгаа нь тэгш бус байдлыг бий болгож, ардчиллын суурь үнэт зүйлийг ганхуулж, нийгмийн тогтвортой хөгжилд томоохон сорилт болж байна.

Дундаж давхарга бол улс орны бүтээгдэхүүн үйлчилгээний тогтвортой хэрэглээ, өсөлтийн гол суурь, шинийг эрэлхийлэгч, эрсдэл гаргагч энтрепренёр, хүмүүн ба санхүүгийн капитал хуримтлуулагч, итгэлцлийг нэмэгдүүлж, ил тод байдал, хариуцлагыг шаардах гол хүчин билээ.

Иймээс дэлхийн улс орнуудын адил хүнээ дээдэлсэн хөгжлийн бодлогын төлөө амьдралын чанарыг дээшлүүлж, дундаж давхаргаа тэлэх зорилго дэвшүүлээ.



АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

ДУНДАЖ ДАВХАРГА ЗОНХИЛСОН НИЙГЭМ

Дундаж давхарга бол аливаа улс орны хөгжлийн гол тулгуур. Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад дундаж давхаргаа дэмжсэн, ялангуяа эрх, гэр бүлийн хөгжих боломж, зохистой хөдөлмөр эрхлэлт, татвар, зээлийн уян хатан бодлого, орон сууцаар хангах, өөрийгөө тэтгэн амьдрах боломж боллоцоог бүрдүүлэх, эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх, тэтгэврийн үеийн хамгаалал, амьжиргаа болон санхүүгийн аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн тусгайлсан бодлогуудыг авч хэрэгжүүлж байна.

Улс орны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч дундаж давхаргын ойлголт өөр өөр байдаг ч нийтлэг үзүүлэлт нь төстэй. Манай улсад дундаж давхаргыг орлого талаас нь үнэлж, амьдралын чанар талаас нь төдийлөн хардаггүй. Дундаж давхаргыг эмч, багш, хуульч зэрэг боловсролтой, боломжийн цалинтай ажилтай, хэт баян биш, хэт ядуу биш нийгмийн бүлгээр тодорхойлох үзэл хандлага бий. Тэд дээд боловсролтой, хэрэглээний орлоготой, өөрийн өмчтэй, тодорхой хэмжээний хуримтлал, хадгаламжтай.

Хөгжингүй орнуудад дундаж давхаргыг бүрдүүлэгчид нь бусадтай харьцуулахад харьцангуй өндөр боловсрол, мэдлэгтэй, тэр хэрээр орлогын хэмжээ өндөр байдаг. Тиймдээ ч дундаж давхарга бүхэлдээ улс төр болон эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, хувь хүний эрх, эрх чөлөөний гол баталгаа болдог.

Ардчилсан нийгэмд сонгосон төрдөө хяналт тавьж, хариуцлага нэхдэг, хамгийн идэвхтэй иргэд нь дундаж давхаргынхан. Тэд нийгмийн үндсэн бүрэлдэхүүн болсноор хөгжлийн замыг тодорхойлоход голлох үүрэг гүйцэтгэнэ.

Дундаж давхарга нь нийгмийн олонх болж чадаагүй, хэт өндөр болон хэт доогуур орлоготой нийгмийн бүлэг нэмэгдэж, ялгаа зааг өссөн улс оронд эдийн засаг, нийгэм, засаглал тогтворгүй, нийгэм нь талцан хуваагдах, зөрчил тэмцэл ихэсдэг байна.



Нөгөө талаар нийгмийн дундаж давхарга зонхилсон үед эдийн засгийн өсөлт илүү байдаг. Учир нь дундаж давхаргын өрхүүд хэрэглээгээрээ дамжуулж, худалдан авалт их хийдэг учраас бизнесийн өсөлт сайн байх нь бий. Мөн хэрэглээ өндөр байхаас гадна хэрэглээний нэр төрөл олон байдаг тул нэр төрөл бүрээр худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэх боломж бүрддэг. Энэ нь хөрөнгө оруулалт нэмэгдэх нөхцөл бүрдүүлдэг. Хэрэглээ өсөж, эрэлт нэмэгдсэнээр эдийн засагт эргэлтийг хурдасгах нөхцөл болно.

Мөн дундаж давхарга ихтэй оронд хуримтлал их байдаг. Дундаж давхаргаас хувиараа бизнес эрхлэгчид их төрж гарч байгаа судалгаанууд байна. Ингэснээр нийгэмд ажлын байр бий болгож, үйлдвэрлэлийн бүтээмжийг өсгөх сайн талтай.

Түүнчлэн тэд нийгмийн итгэлцлийг бэхжүүлж, түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх хандлагатай. Ингэснээр бизнесийн шинэ боломж, гарцыг эрэлхийлдэг бүтээлч санаачилгатай байдаг. Эрсдэл гаргагч энтрепрёнер, хүмүүн ба санхүүгийн капитал хуримтлуулагч, итгэлцлийг нэмэгдүүлж, хэлцлийн зардлыг бууруулагч, ил тод байдал, хариуцлагыг шаардах улс төрийн гол хүчин хэмээн үздэг.

Дундаж давхарга бол ирээдүйдээ хуримтлал бий болгож, хөрөнгө оруулалт хийж, хүүхдүүддээ чанартай боловсрол эзэмшүүлж, өөрсдийн болон гэр бүлийнхээ амьдралыг сайжруулах үүрэг хариуцлага хүлээдэг.

АМЬДРАЛЫН ЧАНАР

Амьдралын чанар гэдэг ухагдахуун энгийн ойлгомжтой мэт төсөөлөгдөж болох ч судлаачид өөр өөрийн үзэл баримтлалд тулгуурлан олон талаас судалж, ялгаатай хэмжүүр, үзүүлэлтээр судлахыг санал болгосон байдаг. Судлаач Эконг (1983), Камбэлл болон бусад (1976), Моррис (1981) нар хүрээлэн байгаа орчин, орон сууц, ажил хөдөлмөр, гэр бүлийн сэтгэл ханамж, аз жаргал, хүн амын нийтлэг сайн сайхан байдлыг амьдралын чанар гэж тодорхойлсон байдаг бол Вильямсон (1987) Остроот, Синдер (1985) нар нийгмийн сайн сайхан байдлын талаарх дээрх тодорхойлолт дээр нэмээд хүмүүсийн хүсэл эрмэлзэл, итгэл үнэмшил, туршлага, нийгмийн халамжийн үр дүн, нийгмийн хүрээлэлтэй холбон амьдралын чанарыг тайлбарлажээ.

Эх сурвалж: Удирдлагын академи, 2018

Нийгмийн эерэг хандлага

Дундаж давхарга нь төрийн үйл ажиллагаа дахь иргэний оролцоог идэвхжүүлж, төрийн үйлчилгээг сайжруулж, төрийн албан хаагчдыг хариуцлагатай ажиллахыг шаарддаг.

Нийгмийн дундаж давхаргын иргэдийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо өндөр; татвар, шимтгэлийн орлого бүрдүүлэлтэд оруулах хувь нэмэр илүү; хөрөнгийн эрх мэдэл бий болгох боломжтой; нийгмийн үүрэг хариуцлагаа ухамсарлаж, хууль дүрэм хэрэгжүүлэх хандлага өндөр байдаг.

Нийгмийн хөгжилд дундаж давхаргын үүрэг, оролцоог чухалчилж ирсэн ч өнөөг хүртэл “дундаж давхарга” гэж яг хэнийг хэлэх вэ гэдэг дээр нэгдсэн ойлголт, зөвшилцөлд хүрээгүй ажээ.


Дундаж давхарга бол ирээдүйдээ хуримтлал бий болгож, хөрөнгө оруулалт хийж, хүүхдүүддээ чанартай боловсрол эзэмшүүлж, өөрсдийн болон гэр бүлийнхээ амьдралыг сайжруулах үүрэг хариуцлага хүлээдэг. Тэдний тоо өсөхийн хэрээр тэд өөрсдийн үзэмжээр олж авсан орлогоо зугаа цэнгэл, амралт, аялалд зугаацуулахад зарцуулж, илүү чанартай, илүү олон төрлийн бараа хэрэглэдэг байв. Дундаж давхарга нь хэрэглээний анги болж эдийн засгийн хөдөлгөгч хүч болдог. Өнөөдөр дэлхий даяар дундаж давхаргын тархалт нь дэлхийн эдийн засгийг тэтгэж буй үндсэн хүчний нэг юм. 2015 онд дэлхийн дундаж давхаргын 3 тэрбум орчим хүн 33 их наяд ам.доллар зарцуулсан нь дэлхийн хэрэглээний зардлын гуравны хоёртой тэнцэж байна.

Жишээ нь, Brookings Institution өдөрт 11-110 ам.долларын орлоготой хүнийг дундаж давхарга гээд 2016 оны байдлаар дэлхийн 3.2 тэрбум хүн энэ бүлэгт хамрагдаж, жил бүр 140 сая хүнээр нэмэгдэж байна гэжээ.

Ази, Номхон далайн бүс нутагт дундаж давхаргын тоо 2030 он гэхэд 3.2 тэрбумд хүрч, 2009 оныхоос 6.2 дахин өсөхөөр байна гэж үзжээ. Үүний гол хөдөлгөгч хүч нь БНХАУ юм. Тус улс хүн амаа ядуурлаас гаргаж, дундаж давхаргаа илүү чинээлэг



Зураг 1. Дэлхийн дундаж давхаргын өөрчлөлт




Эх сурвалж: Statista, 2022

болгоход чиглэсэн бодлого хэрэгжүүлж байна. Дэлхийн хамгийн том үйлдвэрлэгч болсноор эдийн засгийн өсөлтөөс ашиг хүртэж, дундаж давхаргынхны цоо шинэ үеийг “төрүүлсэн”. Дэлхийн банкны тодорхойлсноор Хятад орны нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2017 оны байдлаар 8,800 ам.доллар давсан үзүүлэлтээр “Дундаж давхарга”-ын улс болжээ. Одоогийн байдлаар 400.0 сая гаруй хятад иргэд буюу 140-өөд сая өрхийг дундаж давхаргад тооцож байгаа аж. Энэ нь тус улсын хүн амын ойролцоогоор гуравны нэгтэй тэнцэнэ. БНХАУ-ын Статистикийн үндэсний хорооны мэдээлснээр 2,000-5,000 юанийн орлоготой иргэдийг дундаж давхаргад албан ёсоор багтаадаг бол тус улсын дундаж өрхүүд жилд 25.0-250.0 мянган юанийн орлоготой байна. Хятадын “дундаж давхарга”-ынхны орлого хэдий хөгжингүй болон хурдтай хөгжиж буй улс орны дундаж давхаргынхантай харьцуулахад бага боловч хүн ам ихтэй улсын 140 сая өрх энэ давхаргад хамаарагдаж буй нь дэлхийн эдийн засагт хангалттай сайн үзүүлэлтэд тооцогдож байна.

Судалгааны байгууллагын тооцоогоор АНУ-ын дундаж давхаргын “дундаж” иргэн жилд 26.0-78.0 мянган ам.долларын хооронд хэлбэлзэх орлоготой байдаг. Харин гурван гишүүнтэй дундаж гэр бүлийн жилийн орлого 45.0-135.0 мянган ам.долларын

Нийгмийн дээд давхаргынхан капиталыг хөдөлгөдөг бол дундаж давхаргынхан хөдөлмөрлөх, ажиллах, бүтээх сэтгэлгээтэй байдаг.

Зураг 2. Дэлхийн баялгийн тархалт (хувиар)



Эх сурвалж: Credit Suisse судалгааны хүрээлэн, 2021

Урвуу хамаарал

Дэлхий нийтийн хэмжээнд нийгмийн баялгийн тэгш бус хуваарилалт газар авч, баян хоосны ялгаа ихээр нэмэгдэж, нийгэм хоёр туйлт хэлбэр рүү шилжих хандлага ажиглагдаж байна. Энэ нь ардчиллын томоохон сорилт болж болох юм.

хооронд байдаг аж. 2017 оны судалгаагаар БНСУ-ын дөрвөн гишүүнтэй дундаж давхаргын гэр бүл сарын 4,000 ам.долларын орлоготой байжээ.

Дундаж давхаргын орлогын өсөлтөөс гадна баялгийн тархалтын тэнцвэргүй байдал дэлхий нийтэд түгээмэл ажиглагдах боллоо. Өндөр хөгжсөн орны дунджаас доогуур орлоготой иргэн, хөгжиж буй орны дундаж орлоготой иргэнээс харьцангуй илүү орлоготой. Иймд нэг өдөрт шаардлагатай амьжиргааны түвшин буюу ядуурлын босгыг хүний 1.90 ам.доллар гэдэг өртгөөр ч бас тооцож байна. Судлаачид хөгжиж буй орнуудын дундаж давхарга гэдэгт өдөрт хүний 2-13 ам.доллар, харин зарим нь 10-100 ам.доллараар тооцохыг зөвлөж байна. Олон улсад дундаж давхаргыг тодорхойлохдоо тухайн нийгмийн бүлгийн нийтлэг хэрэгцээ, түүнийгээ хангах бололцоог шалгуур үзүүлэлт болгодог. Үүнийг тооцохдоо өөрийн өмчлөлийн орон сууц, тээврийн хэрэгсэлтэй байх, эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын суурь баталгаа, үр хүүхдэдээ чанартай боловсрол эзэмшүүлэх тогтолцоо, эдийн засгийн чадамж зэргээр нь хэмждэг байна.



Өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн өөр нэг тодорхойлолт бол дундаж давхарга нь хоол, хувцас, орон гэр, боловсрол, эрүүл мэндийн сар тутмын зардлаа төлөөд цаана нь тодорхой хэмжээний хуримтлал хийж чадаж буй айл өрхийг хэлдэг.

Ийнхүү дэлхий дахинд эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг иргэдийнхээ амьдралын чанарын эерэг өөрчлөлт, дундаж давхарга тэлсэн үзүүлэлтээр тодорхойлж байна.

Монгол Улсад дундаж давхаргыг тодорхойлох судалгааг 2014, 2016 онуудад Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ERI) хийжээ. Уг судалгаанд тухайн жилийн өрхийн дунд (медиан) орлогын 67-200 хувьтай тэнцэх орлоготой өрхийг дундаж давхаргад тооцжээ. Судалгаагаар 2002 онд нийт өрхийн 20 хувийг өндөр, 51 хувийг дундаж, 29 хувийг бага орлоготой өрхүүд бүрдүүлж байсан бол 2014 онд нийт өрхийн 14 хувийг өндөр, 61 хувийг дундаж, 25 хувийг бага орлоготой өрхүүд эзлэх болжээ. Манай дундаж орлоготой өрхийн тоо 12 жилийн дотор 10 хувиар нэмэгдсэн гэж үзжээ.

Мөн өрхүүдийн орлогын тэгш бус байдал хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхойлжээ. 2002-2008 оны хооронд дундаж орлоготой өрхийн тоо нэмэгдэж, өндөр орлоготой өрхийн тоо буурсан ч орлого нь хэвээрээ байв. Өрхийн орлогын тэгш бус байдал зөвхөн хот хөдөөд бус, нийслэлийн дүүрэг хооронд ч байна. Бага орлоготой өрхийн тоо нийслэлийн төвийн дүүргүүдэд захын дүүргүүдтэй харьцуулахад цөөн байна.

Иймд дундаж давхаргыг илүү тэлж бэхжүүлэн, эрсдэлээс хамгаалах, орлого багатай иргэн, өрхийг дундаж давхаргад оруулах бодлогыг хэрэгжүүлэхийг зорьж байна. Ингэхдээ орон сууцны бодлого, боловсролын тэгш байдал, жижиг дунд үйлдвэрлэлд ээлтэй зээлийн бодлого, авлига, хүнд суртлаас ангид нийгэм зэргээр нийгмийн баталгааг хангах зорилгоо тодорхойлсон.

Дундаж давхаргыг бэлтгэх нь Улс орны дундаж давхаргыг боловсролд хөрөнгө оруулах замаар бэлтгэдэг жишиг бий.

ОРЛОГЫН ГОЛЧ УТГА

Орлогын голч утга (медиан) гэдэг нь хүн амыг орлогын хэмжээгээр нь хоёр тэнцүү хэсэгт хувааж буй утга юм. Дундаж давхаргыг тооцоходоо үүнийг ашиглаж байна. Хүн амын 50 хувь нь орлогын утга хүртэл, үлдсэн 50 хувь нь орлогын голчоос өндөр орлоготой байна гэсэн үг.

АНУ-ын Пью судалгааны төвөөс гаргасан аргачлал болох орлогын голчийн 67-200 хувьтай тэнцүү орлоготой бол дундаж давхаргад хамааруулдаг тооцоолол нь орлогын тархалтыг баримжаалсан харьцангуй хэмжүүр болно.

Эх сурвалж: Удирдлагын академи, 2022

АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ БА ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ

ЗОРИЛТ 3.1 Амьдралын баталгааг ханган нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030


Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Эрсдэлээс сэргийлсэн нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Амьдралын чанарыг сайжруулахуйц нийгмийн хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх үе



Нийгмийн хамгаалал гэдэг нь хүн амыг нийгэм, эдийн засгийн эмзэг байдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн төрийн болон хувийн хэвшлийн бодлого, хөтөлбөрүүдийн цогц ойлголт юм. Нийгмийн даатгал нь иргэн болон төр аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болох эрсдэл учирвал өөрт нь тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх тухай арга хэмжээ юм.

НИЙГМИЙН ДААТГАЛ

Дундаж давхаргыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой асуудал нь нийгмийн даатгалын тогтолцоо буюу нийгмийн хамгаалал, халамжийн цогц үйлчилгээ юм. Нийгмийн хамгааллын үйлчилгээ нь хүний үндсэн эрхээс гадна хүний сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн төрийн арга хэмжээ юм.

Дэлхийн улс орнуудад нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрөө хэрэгжүүлэхдээ нийгмийн даатгал, нийгмийн халамж гэсэн үндсэн арга хэрэгслийг ашигладаг.



Зураг 3. Нийгмийн даатгалын тогтолцоо




Эх сурвалж: ХНХЯ, 2021


Манай улсын нийгмийн хамгааллын тогтолцоо нь орлого багатай, эмзэг бүлгийн иргэдэд тусламж, дэмжлэг үзүүлэх, ажилгүй, өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй болох үеийн эрсдэл, эмзэг байдал, орлогын бууралтыг хамгаалахад чиглэсэн нийгмийн даатгалын бодлого хэрэгжүүлж байна.

Манай улс эв санааны зарчимд суурилсан нийгмийн даатгалын тогтолцоотой. Энэ нь даатгуулагчдын төлсөн шимтгэлээс бүрдсэн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр олгодог тогтолцоо билээ. 2020 оны байдлаар эдийн засгийн идэвхтэй хүн амын 51.7 хувь нь нийгмийн даатгалд даатгуулсан байна. Тэтгэвэр авагч (нийт) нэг иргэнд ногдох даатгуулагчийн тоо 2.7 байгаа ба өндөр насны тэтгэвэр авагч нэг иргэнд ногдох даатгуулагчийн тоо 3.7 байна. Дэлхийн хүн амын өсөлтийн хандлагаас харахад хүн амын төрөлтийн түвшин буурч, хүн амын амьдрах чадвар сайжирч, хүн урт удаан наслах байдал улам бүр нэмэгдэж байна. Үүний дүнд дэлхийн хүн амын өсөлт харьцангуй тогтвортой буурах хандлагатай болж, хүн амын насны бүтэц хөгширч, дэлхий нийтээрээ ирэх он жилүүдэд насажсан нийгэмд амьдрах төлөвтэй байна. Үүний адил манай улсын хувьд ч цаашид хөдөлмөрийн насны хүн амд ногдох тэтгэврийн насны хүн амын тоо нэмэгдэх хэтийн тооцоолол байгаа тул нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх нь чухал болж байна. Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хөдөлмөрийн бус насны хүн амын тоо 59.5 байгаа бол 2050


Өндөр настны тэтгэвэр



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр



Бусад тэтгэвэр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2022

Нийгмийн даатгалын шинэчлэл

Нийгмийн даатгалын тогтолцооны өнөөгийн төлбөрийн балансын алдагдалтай тогтолцоог шинэчилснээр ирээдүйгээс зээлдэг биш, өөрөө өөрийгөө тэтгэдэг тогтолцоог боломж бүрдэнэ.

Үзүүлэлт	2020
Нийгмийн даатгалд даатгуулагчид	1,013,190
Албан журмаар даатгуулагчид	826,064
Сайн дураар даатгуулагчид	187,126

Хүн амын насжилт нэмэгдэж, даатгуулагчдад ногдох тэтгэвэр авагчдын тоо нэмэгдэнэ. Иймд төрөлтийг дэмжих, насжилтын нөхцөл байдалд нийцүүлэн тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай.


онд 100 хүнд ногдох хөдөлмөрийн бус насны хүн амын тоо 71.1 болохоор байна. Иймээс одоо байгаа эв санааны зарчимд суурилсан нийгмийн даатгалын тогтолцоог хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцоонд үе шаттай шилжүүлэх зорилгоор энэ ажлыг хууль, эрх зүйн орчин, салбарын бодлогын шинэчлэлээс эхлүүлж байна.

Энэ хүрээнд нийгмийн даатгалын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулах, даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох замаар нийгмийн даатгалын тогтолцооны цогц шинэчлэлийн суурийг тавина.

Албан журмаар даатгуулагчаас гадна албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, өрхийн болон хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, малчдын нийгмийн баталгааг хангах, тэднийг нийгмийн даатгалд даатгуулах ажлыг нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах ажлыг эрчимжүүлнэ.


Нийгмийн даатгал нь даатгуулагчийн хөдөлмөрөөрөө бий болгосон өнөөгийн болон ирээдүйн амьдралын баталгаа. Тиймээс нийгмийн даатгалын үйлчилгээ ажил, хөдөлмөр эрхэлсэн цагаас эхлэн даатгуулагчид ээлтэй, үр дүнтэй байх учиртай. Нийгмийн даатгалыг дагасан эрүүл мэнд, боловсрол, нийгмийн суурь олон үйлчилгээг цогцоор нь хүртээмжтэй авдаг байх нь чухал. Тиймээс даатгалын үйлчилгээг зөвхөн хуримтлалын эх үүсвэр болгож, монгол хүн бүрийг хуримтлалтай болгохыг зорьж байна.

Зураг 4. Тэтгэвэр авагчид ногдох даатгуулагчдын тоо





Зураг 5. Хөдөлмөрийн насны хүн амын өөрчлөлт




Эх сурвалж: YCX, 2021

Монгол Улсын нийт хүн амын дотор хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь буурч байгаа нь цаашид даатгуулагч, тэтгэвэр авагчдын харьцааг алдагдуулах эрсдэлтэй юм. Манай улсын нийгмийн даатгалын тогтолцоо өнөөгийн эв санааны нэгдлийн зарчимд тулгуурласан хэвээр байх тохиолдолд энэ нь нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын харьцааг алдагдуулан, хүрэлцээг бууруулах, улмаар нийгмийн хамгааллын тогтолцоог доголдуулахад хүргэх эрсдэлтэй.

Зураг 6. Тэтгэвэр авагчдын өсөлтийн төсөөлөл

Өндөр насны тэтгэвэр авагчдын тоо, төсөөлөл (мянган иргэн)



Эх сурвалж: ХНХЯ, 2021

Нийгмийн хамгааллын тогтолцоо гэдэг нь төр иргэнээ тодорхой эрсдэлээс хамгаалах үүргээ биелүүлэх арга хэмжээний цогц юм. Үүний үндсэн бүрэлдэхүүн хэсэг бол нийгмийн даатгалын тогтолцоо билээ.

Түүхийн бүх цаг үед аль ч нийгэмд халамж зайлшгүй шаардагдах зорилтот бүлэг хүн амын тодорхой хувийг эзэлсээр ирсэн. Тэрхүү бүлэгт зориулсан төрийн бодлого улс орон бүрд байдаг. Энэ нь нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх, хүмүүнлэг энэрэнгүй ёсны зарчим батжих үндэс болдог.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамж нь хүн амын хамгийн эмзэг ядуу хэсгийн амьжиргаанд дэмжлэг үзүүлж, ядуурлыг бууруулах, бусдын туслалцаагүйгээр бие даан амьдрах чадваргүй төрөөс зайлшгүй харж хандах шаардлагатай хүн амын эмзэг хэсгийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилготой юм. Тиймээс улс орнууд нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн бодлого боловсруулж, тэдгээрийг санхүүжүүлж байдаг билээ. Улс орнуудад нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, нийгмийн байгуулал, соёл, уламжлал, байгаль цаг уур, үйлдвэрлэл, эрхэлж буй аж ахуйн онцлог зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалсан харилцан адилгүй нийгмийн халамжийн тогтолцоо оршин үйлчилж байна.

Амьдралын наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа хэсэг бүлгийг зорилтот бүлэг гэж үздэг. Төр эдгээр хүмүүсийг ялгаварлан гадуурхалтад өртүүлэхгүйн тулд олон талт цогц арга хэмжээ авч хэрэгжүүлдэг билээ.


Хүснэгт 1. Нийгмийн халамжийн сангийн зардал, хөтөлбөрөөр (2020-2021 он, тэрбум төгрөгөөр)

Төрөл	2020 он		2021 он	
	Хүний тоо	Хөрөнгийн хэмжээ	Хүний тоо	Хөрөнгийн хэмжээ
Нийгмийн халамжийн тэтгэвэр	60,359	162.9	74,571	184.4
Асаргааны тэтгэмж	64,769	58.5	65,191	59.4
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	56,607	39.0	57,742	43.6
Онцгой тохиолдлын тэтгэмж	1,523	1.9	1,117	1.3
Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	7,543	11.0	8,027	11.9
Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	241,988	55.4	167,280	31.0
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ болон асрамжийн үйлчилгээ	11,352	1.7	9,204	2.2
Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	264,422	28.3	211,644	17.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх дэмжлэг, тусламж	53,931	10.8	46,083	9.3
Цаатны тэтгэмж	368	0.7	395	0.8
Нийгмийн халамжийн зардал		371.2		361.4
Цалинтай ээж /0-3 хүүхэд асарсны болон ихэр хүүхэд/	200,054	92.5	207,076	91.4
Хүүхдийн мөнгө	1,186,289	1,053.0	1,220,158	1,336.3
Насны хишиг	142,590	22.7	157,697	24.0
Жирэмсэн эхийн тэтгэмж	84,752	12.7	83,819	11.3
Алдар цолтон ахмад настанд төрөөс өгөх нэмэгдэл, тусламж хөнгөлөлт	5,504	5.1	86	0.31
Эхийн алдарт одонтой эхчүүдэд жилд 1 удаа олгох мөнгөн тусламж	231,452	29.8	239,303	30.5
Нийтлэг мөнгөн тусламжийн зардал		1,215.8		1,493.8
НИЙТ		1,587.0		1,855.2

Эх сурвалж: ХНХЯ, 2021



Зураг 7. Нийгмийн халамжийн үйлчилгээ



Эх сурвалж: ХНХЯ, 2021

Нийгмийн хамгаалал нь улс орны хэмжээнд эдийн засгийн, нийгмийн болон хүн ам зүйн чиг үүргийг гүйцэтгэдэг. Эдийн засгийн талаас орлогын дахин хуваарилалт хийх замаар ядуу, эмзэг бүлгийнхний орлогыг нэмэгдүүлэх; эрсдэлд өртөн орлогын түвшин буурах үед түүнийг тодорхой түвшинд нөхөх; хөдөлмөр эрхлэлтийн үндсэн дээр өрх, иргэдийн орлогын баталгаат байдлыг хангах зэрэг үүргийг дурдаж болно. Нийгмийн хамгаалалд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулах, хөдөлмөрийн чадвараа алдах, өндөр наслах зэрэг эрсдэлийн үед иргэн бүрд хэвийн амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх нийгмийн шинжтэй чиг үүрэг ч бий. Иймээс халамжаас хөдөлмөрт гэсэн зарчим баримталж, зорилтот бүлгийн өрхийн гишүүдийг ажлын байраар хангах бодлого хэрэгжүүлнэ. Нийгмийн хамгааллын хүрээнд төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөн, гэрлэлт зэрэг хүн ам зүйн үйл явц, түүний үр дүнд буюу хүн амын өсөлт, хөгжилд шаардлагатай ээлтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх үүрэг бий. Үүнээс эх хүүхдийн тэтгэмж зэрэг нийгмийн хамгааллын үйлчилгээг хүн амын өсөлтөд чиглүүлэн гэр бүлд ээлтэй байдлаар тодорхойлон хэрэгжүүлнэ.

Нөгөө талаар нийгмийн хамгаалал нь хүн амын өсөлтийг дэмжих, эх хүүхэд, гэр бүлд ээлтэй бодлогын үндэс суурь болох ба хүн амын өсөлт, хөгжил; нийгмийн бүлгүүдийн өвөрмөц хэрэгцээг харгалзсан халамж, хамгааллын үйлчилгээ чухал болохыг онцгойлон анхаарсан билээ.

Монгол улсад 2021 оны байдлаар нийгмийн халамжийн 17 төрлийн үйлчилгээнд нийт 1.9 их наяд төгрөг зарцуулсан байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээний үр нөлөөг дээшлүүлэх хүрээнд халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт оновчтой чиглүүлэх, ингэхдээ мэдээллийн систем, технологийн шинэчлэлтийг хийх; зорилтот бүлэгт ногдох тусламж үйлчилгээг хэрэгцээнд тулгуурлан орон нутгийн онцлогт нийцүүлэн олгох зэрэг ажлыг хэрэгжүүлэхийг зорьж байна.

Манай өнөөгийн нийгмийн даатгалын тогтолцоо эв санааны нэгдлийн зарчим дээр суурилдаг. Гэвч энэ нь тэтгэврийн сангийн алдагдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Иймээс уг тогтолцоог үе шаттай шинэчилж, улмаар 2050 он гэхэд бүрэн хуримтлалтай тогтолцоонд шилжихээр төлөвлөсөн болно.

**ХУВААРИЛАЛТЫН
ТОГТОЛЦООНООС ХУРИМТЛАЛЫН
ТОГТОЛЦООНД ШИЛЖИНЭ**



**БҮРЭН ХУРИМТЛАЛЫН
ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ**
Бүрэн хуримтлалын тогтолцоог
нэвтрүүлэх эхний үе шат

2041-2050



**ХАГАС ХУРИМТЛАЛЫН
ТОГТОЛЦООНД ШИЛЖИХ**
Нэрийн дансыг үе шаттай
мөнгөжүүлж, хөрөнгө оруулалт хийх

2023-2040



**ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН
САНТАЙ УЯЛДУУЛАХ**
Хууль эрх зүйн шинэчлэл

2021-2023

ХУРИМТЛАЛТАЙ МОНГОЛ

Манай улс нийгмийн даатгалын тогтолцоог хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцоонд үе шаттай шилжүүлэх, шинэчлэл хийх зорилго дэвшүүлсэн билээ.

Энэ хүрээнд иргэдийнхээ нийгмийн хамгааллын бүх төлбөрийг нэгдсэн санд хуримтлуулж, хүн бүрийн амьдралыг сайжруулахад оновчтой ашиглаж, хуримтлалын нэгдсэн тогтолцоогоо бэхжүүлж чадсан улс бол Сингапур юм. Тус улс 1953 онд “Хуримтлалын нэгдсэн сан” бий болгосон. Энэ санг үе шаттай хөгжүүлж, иргэдийнхээ орон сууц, эрүүл мэнд, боловсрол, өндөр насны хэрэгцээг хангах хамгийн оновчтой хувилбар болгосон. Нэг үгээр хэлбэл, хувь хүний хуримтлал бий болгож, тухайн хүн, түүний гэр бүл хуульд заасан ямар нэг хэлбэрээр буцаан авах боломжтой юм. Сингапур улс нийгмийн хамгаалал гэдэгт хуримтлалтай, хувийн хадгаламж, даатгалтай байх, гэр бүлийн дэмжлэг буюу хуримтлалын сангаас нөгөө гишүүндээ шилжүүлэх, сайн дурын ажил хийхэд урамшуулалтай байх, орон сууц авах, эмнэлгийн тусламж авах зэрэг багтдаг аж. Хуримтлалын тогтолцоог бий болгохоор зорьж байгаа манай улсын хувьд Сингапур улсын хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцоог бүрдүүлсэн туршлагаас суралцаж, өөрийн улсдаа нутагшуулах боломжтой.

Манай улс тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжиж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно. Улмаар тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын

ХУВААРИЛАЛТЫН БОЛОН ХАГАС, БҮРЭН ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦОО

Улс орнуудад тэтгэврийг Хуваарилалтын (Pay as you go); Хуримтлалын (Full funding); Хагас хуримтлалын (Partial funding) гэсэн үндсэн гурван аргаар санхүүжүүлнэ. Хуваарилалтын арга нь өнөөдрийн тэтгэврийн сан бүрдүүлэгчдийн хөрөнгөөр өнөөдрийн өндөр настнуудын тэтгэврийг төлж буй арга юм. Эв санааны нэгдлийн зарчимд суурилсан гэж нэрлэгдэх уг арга нь тэтгэврийн эх үүсвэрийг шууд хуваарилж байгаа учир хуримтлал бүрдэхгүй. Хуримтлалын арга гэдэг нь тэтгэвэрт гарсны дараа өөрт шаардлагатай болох хөрөнгийн эх үүсвэрийг даатгуулагч өөрөө бүрдүүлэх хэлбэр юм. Хагас хуримтлалын арга нь хуваарилалтын болон хуримтлалын аргыг хослуулан ашигладаг завсрын хэлбэрт хамаарна. Хагас хуримтлалын нөхцөлд даатгуулагчдын шимтгэлээр боломжийн хэмжээний хөрөнгө хуримтлуулж болох ч тэтгэврийн хэмжээ бага байна.

Эх сурвалж: Удирдлагын академи, 2022




тогтолцоонд шилжүүлэх юм. Өөрөөр хэлбэл тэтгэврийн даатгалд хамрагдсан хэн бүхэн бодит хуримтлалтай болох юм.

Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийн тандан судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хийж, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, хувь хүний хуримтлалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу иргэн бүрд хуваарилсан байгалийн баялгийн орлогоос, хувьцааны ногдол ашгийн орлого, нэрийн дансны тодорхой хувийг мөнгөжүүлсэн орлого, иргэнээс хийх нэмэлт орлого, төрөөс хэрэгжүүлж байгаа холбогдох бусад хөтөлбөр, ажил олгогчоос ажилтнаа дэмжиж хийх тодорхой орлого зэргээс бүрдүүлэхээр урьдчилан тооцоолсон.

Хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцоо нь нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгох улмаар ашигт малтмалын орд газрын орлогын өгөөж бусад санхүүжилтийн эх үүсвэрээс тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх замаар тогтолцооны шилжилтийн үеийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр тооцоолж байна. Манай улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл, баялгийн нөөц, хөгжлийн түүхтэй төстэй улс орнууд, бусад улсад амжилттай хэрэгжиж, туршигдсан туршлагаудыг судалж хэрэгжүүлнэ. Иргэд сангийн дэмжлэгээр үндсэн суурь асуудлаа шийдэхэд дэмжлэг хүртэх боломжтой болно. Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжих бодлого юм.

Дундаж давхаргыг тэлэх бодлоготой уялдах гол зорилтын нэг бол хуримтлалын нэгдсэн санг байгуулах явдал юм. Уг сангаар дамжуулж иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжинэ.

Зураг 8. Хуримтлалын нэгдсэн сан (эх үүсвэр, зарцуулалт)



Эх сурвалж: ХНХЯ, 2022

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ

Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг хийнэ. Тэтгэврийн даатгалыг хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжүүлж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлнэ. Нийгмийн даатгалын засаглал, хөрөнгө оруулалтын тогтолцоог сайжруулж, даатгуулагчдын хамрах хүрээг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулж, их өгөгдөлд суурилсан тооцоо, судалгаанд үндэслэн нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлнэ. Иргэн төрийн болон хувийн тэтгэврийн санд давхар даатгуулах боломж бүрдүүлснээр иргэдэд давхар боломж нээгдэхээс гадна санхүүгийн зах зээлийг дэмжих юм.

Зураг 9. Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэл

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ




Эх сурвалж: ХНХЯ, 2022



МОНГОЛ ХҮН БҮР ЭРХЭМ

Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоо нь нийгмийн даатгалын санг төр, ажил олгогч, даатгуулагч хамтран бүрдүүлсний үндсэн дээр даатгуулагч иргэдэд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал авах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгож, иргэдийнхээ нийгмийн баталгааг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Зураг 10. Нийгмийн даатгалын хамрах хүрээ



Эх сурвалж: НДЕГ, ОУХБ, 2021






ИРГЭНИЙ ХҮСЭЛ ИРЭЭДҮЙН ТОЛЬ

Хүн бүр сайн сайхан, элбэг хангалуун, эрүүл энх, элэг бүтэн амьдрахыг хүсдэг. Ард иргэдийнхээ сайн сайхан амьдралын хөрс суурийг бэлдэх, улам бадрах, хэрэгтэй үед нь тусалж дэмжих нь төрийн үндсэн үүрэг. Монгол Улсын иргэн, Монгол хүн бүр төрдөө эрхэм.



Зураг 11. Монгол Улсын өрх, орон сууцны тоо (2020 оны байдлаар)

Монгол Улсын өрх, орон сууцны тоо (2020 оны байдлаар)

				
Өрхийн тоо	Орон сууц	Хаус	Байшин	Гэр
Нийслэл 606,282 /68%/	254,538 42%	5,903 1.0%	195,968 32%	149,873 25%
Орон нутаг 291,145 /32%/	9,778 3%	537 0.2%	88,294 30%	192,536 66%
Монгол Улс 897 427 /100%/	264,316 29%	6,440 1.0%	284,262 32%	342,409 38%

Эх сурвалж: УСХ, 2020

Нийт өрхөөс 606.3 мянган буюу 68.0 хувь нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна. Нийслэлийн хэмжээнд нийт өрхийн 43 хувь нь орон сууцны хороололд буюу инженерийн дэд бүтцийн хангамжид бүрэн холбогдсон сууцанд амьдарч байгаа бол гэр хороололд 57.1 хувь инженерийн дэд бүтцэд холбогдоогүй сууцанд оршин сууж байна.

Улаанбаатар хотын орон сууцанд амьдарч буй өрхийн 18.4 хувь нь 30 м² хүртэл, 63.3 хувь нь 31-60 м² талбайтай байранд амьдарч байна. Ихэнх айлууд жижиг м²-тай байр сонгох хандлагатай байгаа нь байрны үнэ өндөр, иргэдийн худалдан авах чадавх сул байгаатай холбоотой.


Зах зээл дээр борлогдоогүй эзнээ хүлээж байгаа 30.0 мянга орчим орон сууц байгааг судалгаагаар тогтоосон байдаг бөгөөд нийлүүлэлтийн илүүтэй мэт харагдаж байгаа боловч эрэлт талаасаа орон сууцанд орох хүсэлтэй 200.0 гаруй мянган өрх Улаанбаатарт амьдарч байна. Үүнээс 35.0 мянган өрх нь л худалдан авах чадвартай байна.

Зах зээл дээр нийлүүлэгдэж байгаа арилжааны зориулалттай орон сууцыг дунд болон дундаас дээш орлоготой өрх худалдан авах чадвартай ба зах зээлийн харилцаагаараа зохицуулагдаад явах боломжтой.

Ирэх таван жилд нийслэлийн 216.0 мянга гаруй өрх, орон нутгийн 121.9 мянган өрх орон сууц худалдан авах тооцоотой байгаа нь орон сууцны эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байна.

Зураг 12. Орон сууцны барилга ба ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо

АШИГЛАЛТАД ОРСОН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА, ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ТОО, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ



Монгол Улсын Засгийн газраас үеийн үед шат дараатайгаар хэрэгжүүлж ирсэн бодлого бол иргэдээ ая тухтай, амьдрах таатай орчин бүхий орон байраар хангах зорилт байсаар ирсэн билээ.

Иргэдийг орон сууцжуулахад ипотекийн зээл голлох ач холбогдолтой бөгөөд ипотекийн зээлийн хангамж нэмэгдсэн үед орон сууцны үйлдвэрлэл борлуулалт ихсэж, суларсан үед багасдаг зүй тогтолтой байна.

2013 оноос эхлэн төрөөс хэрэгжүүлж эхэлсэн ипотекийн жилийн 8 хувийн хүүтэй орон сууцны зээл нь иргэдэд үр өгөөжөө өгч, зээл олгож эхэлснээс хойш 2021 оны байдлаар 104.4 мянган иргэн хамрагдаж, өөрийн эзэмшлийн орон сууцтай болсон байна.

Гэвч өрх бүр хангалттай хуримтлалгүйгээс орон сууцны төлбөрийн 30 хувийг урьдчилгаа бүрдүүлэх чадваргүй байгаа нь бага дунд орлоготой иргэд болон зорилтот бүлгийг орон сууцжуулах төрийн бодлогын томоохон сорилтын нэг болж байна.

Орон сууцжуулах аливаа хэлбэр нь нийгмийн, хүн ам зүйн, байгаль орчны, эдийн засгийн өндөр ач холбогдолтой. Тухайлбал, бага насны хүүхдийн гэнэтийн осол, эндэгдэл, хүчин, дээрэм, булаалт зэрэг гэмт хэрэг, зөрчил, гал түймрийн аюул, гал түймрээс үүдэлтэй осол, гэмтэл, угаартах зэрэг гэнэтийн эрсдэл буурах, агаар орчин, хөрсний бохирдол багассанаар үүнээс үүдэлтэй амьсгалын замын өвчлөл, нялхсын болон ургийн эндэгдэл буурах, орчны аюулгүй байдал хангагдах, нийгэм соёлын ялгаа арилах суурь нөхцөл болдог. Улмаар амьдралын чанар дээшлэх үндэс билээ.

Олон улсад “төлбөрийн чадварт нийцсэн орон сууц” гэдэгт хүн амын зорилтот бүлгийн иргэд урт хугацаанд төлж чадахуйц буюу орон сууцны өртөг нь бага байх нөхцөлийг хэлдэг. Олон оронд энэхүү боломжит төлбөрийн чадавхыг тодорхойлохдоо өрхүүдийн орон



сууцтай холбоотой зардалд сарын орлогын 30 хувийг зарцуулж буй чадамжаар нь тодорхойлдог.

Иймээс иргэдийг орон сууцжуулах, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжих, иргэдийн орон сууц худалдан авах чадавхыг нэмэгдүүлэх санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх, орон сууцны өртөг бууруулах зорилтыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн билээ.

Зорилтын хүрээнд орлогод нийцсэн орон сууцны бүтээн байгуулалт нь ногоон хөгжлийн загварт нийцсэн байх, дэд бүтэц, хангамж, орчны хувьд стандарт шаардлагад нийцсэн байхад онцгой анхаарч байна.

Мөн төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтэц бүхий орон сууцны хангамжийг дээшлүүлэх чиглэлд гадаад, дотоодын байгууллага, хувийн хэвшлийн олон талт санхүүгийн эх үүсвэрийг ашиглахаар төлөвлөсөн. Түүнчлэн иргэдэд зээлийн хөрөнгөөр орон сууц худалдан авах боломжийг бүрдүүлэх үүднээс ипотекийн зээлийн хамрах хүрээг өргөжүүлэх, уян хатан нөхцөлтэйгөөр, олон хувилбартай байх боломжийг судлан хэрэгжүүлэх юм.

Бүгд нэг дор

Орчин үед хүний хэрэгцээ улам өргөжиж, олон талт болсоор байна. Тэр бүх хэрэгцээг аль болох хялбар дөт аргаар, орон зай, цаг хугацааны хувьд хэмнэлттэй байдлаар хангах нөхцөлийг бий болгох нь амьдралын таатай орчны маш чухал бүрдэл хэсэг юм.

Зураг 13. Амьдрах таатай орчин бүхий орон сууцны стандарт



ОЛОН НИЙТЭД
ЗОРИУЛСАН АРГА
ХЭМЖЭЭ



ДЭЛГҮҮР
ХУДАЛДААНЫ ТӨВ



УХААЛАГ
ҮЙЛЧИЛГЭЭ



ШИНЭ
НАЙЗ НӨХӨД



АВТО МАШИНЫ
БОЛОН ДУГУЙН
ЗОГСООЛ



ХОТЫН
СОЁЛ



НОГООН
БАЙГУУЛАМЖ



АЙЛ ӨРХИЙН
ХАРИЛЦАА, ХОЛБОО



РЕСТОРАН, ЗООГИЙН
ГАЗАР



СПОРТ ЗААЛ,
ФИТНЕС ТӨВ



ХҮҮХДИЙН
ТОГЛООМЫН ТАЛБАЙ



СУРГУУЛЬ,
ЦЭЦЭРЛЭГ



АМЬДРАХ ТААТАЙ ОРЧИН

Зээлийн таатай нөхцөл

Дэлхийн аль ч улсад орон сууц шууд худалдан авах гэдэг дундаж орлоготой хүн амынх нь хувьд санхүүгийн маш том дарамт болдог. Иймээс орон сууцанд тусгайлан зориулсан хөнгөлөлттэй зээлийг иргэддээ санал болгох замаар дэмжлэг үзүүлдэг учиртай.

Иймд орлогод нийцсэн орон байраар хангах зорилтыг хэрэгжүүлэхэд барилгын материалын үнийг бууруулах, цемент, арматур зэрэг гол нэрийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, төрөөс дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлт хийх, шийдвэрлэх зэргээр төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх юм.

Орон сууцыг иргэдийн орлогод нийцсэн өртөгтэй болгох зорилгоор боломжит газрууддаа төрөөс дэд бүтцийн төлөвлөлт хийж, инженерийн шугам сүлжээ байгуулж, хувийн хэвшлийнхэнд барилга барих боломжийг нээж өгснөөр иргэдээ өртөг багатай орон сууцаар хангах боломж бүрдүүлнэ.

Хот суурин газрын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ. Иргэдийн хүсэл санаачилгад үндэслэн дэд бүтэц бүхий газрыг төр эсвэл хувийн хэвшлийн орон сууцаар солих замаар дараагийн орон сууц баригдах талбайг бий болгохыг зорьж байна.

Зураг 14. Орон сууцны төлөвлөлт

ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ



НИЙТ Улаанбаатар хот: 100,000

Орон нутагт: 50,000





ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ

Дэлхийн улс орнууд орон сууцны өмчлөлийг дэмжих бодлого хэрэгжүүлдэг ч энэхүү стратеги нь дэлхийн аль ч өнцөгт орон сууцны асуудлыг бүрэн шийдэж чадаагүй бөгөөд 1.2 тэрбум орчим түрээслэгчид байгаа нь түрээсийн орон сууц нь зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүн болохыг харуулж байна. Төр, орон нутаг, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийгмийн зорилтот бүлгийн иргэдийг хямд үнэтэй орон сууцаар хангана.

Орон сууц худалдан авах боломжгүй, түрээсийн орон сууцанд амьдрах сонирхолтой иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн өмчийн бүх хэлбэрийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, иргэдийн орон сууцны хангамж нөхцөлийг сайжруулахад түрээсийн орон сууцны зорилго оршино. Мөн түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, харж хандах үр хүүхэдгүй ахмад настан, бүтэн өнчин хүүхэд залуучууд, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр орон гэргүй болсон айл өрх, ажил амьдралын гараагаа эхэлж байгаа залуу гэр бүл, төв суурин газарт түр хугацаагаар ирж ажиллаж, суралцаж байгаа оюутан залуусын түр амьдрах орон байрны асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой юм. Олон улсын туршлагаас харахад өмчийн бүх хэлбэрийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх ажлыг төрөөс бодлогоор дэмжин бага, дунд орлоготой иргэд, залуу гэр бүл, нийгмийн зорилтот бүлгийн орон сууцны хэрэгцээг хангадаг байна.

Нийгмийн олон бүлгүүд, залуучууд, шилжин суурьшигчид, шинээр гэр бүл болсон өрхүүдийг түрээсийн орон сууцаар хангах боломжтой байснаар нийгмийн дундаж давхаргыг бүрдүүлэх чухал хөшүүрэг болж өгдөг.

Зураг 15. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хангамж нэмэгдүүлэх арга хэмжээ



Эх сурвалж: УСХ, 2021



Нэгдсэн төлөвлөлт

Орон сууцны үнэ бууруулах нэг механизм бол нэгдсэн төлөвлөлттэй орон сууцыг иргэдэд санал болгодог Сингапурын туршлага юм. Энэ нь санхүүгийн боломжид нийцсэн шийдэл юм.

СИНГАПУРЫН ТУРШЛАГА

Сингапур улсын нийтийн орон сууцны салбарт гаргасан гайхалтай амжилт нь дэмжигчид болон шүүмжлэгчдийг алмайруулжээ. Сингапурын Засгийн газар 25 жилийн дотор хүн ам ихтэй, ядуу, ядуусын хороололд дүүрсэн гуравдагч ертөнцийн арлыг гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан гайхам газар болгон хувиргасныг олон хүн магтдаг. Өнөөдөр Сингапурын нийт хүн амын 85 хувь нь Орон сууц, хөгжлийн зөвлөл (HDB)-өөс төлөвлөж, барьсан өндөр байшинд амьдардаг. HDB-ийн оршин суугчдын 94 орчим хувь нь орон сууцаа эзэмшдэг бөгөөд ердөө зургаан хувь нь түрээслэгчээр үлдсэн. Сингапурын нийтийн орон сууцны хөтөлбөр нь нэг км² талбайд 6,220 хүн амын нягтаршил өндөртэй хотын өмчлөлийн хүртээмжээрээ гайхалтай юм. 1960-аад оны эхэн үеэс эхлэн орон сууцны эрэлтийг хангах үүднээс өндөр, өндөр нягтаршилтай нийтийн орон сууцны загварыг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү загвар нь тогтвортой үргэлжлэх төлөвтэй байгаа бөгөөд ирээдүйн хэрэгцээг хангах орон сууцны үндсэн хэлбэр байх болно.

Чанартай амьдралын үндэс нь орон сууцны үндсэн хэрэгцээг хангах юм. Орон сууцны бодлогыг тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засагт эерэг үр дүн бий болгож, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлсэн.




Тухайлбал, иргэдийн орон сууц худалдан авах санхүүжилтийн тогтолцоог Хуримтлалын нэгдсэн санд үндэслэн хэрэгжүүлсэн нь нийтийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлсэн.

Сингапурын үндэсний орон сууцны бүтээн байгуулалтыг хийхдээ төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан, хувийн хэвшлийнхнийг татан оролцуулах бодлого баримталж ажилласан нь үр дүнгээ өгсөн юм. Ингэхдээ зөвхөн орон сууц барих бус, иргэд ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, тогтвортой хөгжлийн үндсийг хангах, байгаль орчинд ээлтэй ногоон байгууламж бүхий цогц төлөвлөлт, нэгдсэн стандартыг хэрэгжүүлж ажилласан байна.

Иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангахдаа хотын түгжрэл, иргэдийн нийгмийн оролцоо, гэр бүлийн тогтвортой байдлыг бүрдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг бусад салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлсэн. Жишээлбэл, гурван үеэрээ хамт амьдрахаар байр сонгож байгаа гэр бүлд хотын түгжрэлийг бууруулахад оруулсан хувь нэмрийг үндэслэх, шинэ гэр бүл болж байгааг харгалзан үзэж тодорхой хэмжээний хөнгөлөлт үзүүлэх гэх зэрэг арга хэмжээг уялдуулан хэрэгжүүлдэг байна.

Сингапурын орон сууцны эзэмшлийн бүтэц



Зураг 16. Иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангах бодлого

ИРГЭДИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРТ НИЙЦСЭН ОРОН СУУЦААР ХАНГАХ

Санхүүгийн боломж, хэрэгцээнд тулгуурлан санал болгож буй байрны төлөвлөлтүүд



ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН АМЖИЛТЫН НЭГ СУУРЬ НӨХЦӨЛ НЬ БАРИЛГЫН НЭГ МАЯГИЙН ЗУРГААР БАРЬСАН ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ ЮМ.

ЗАЛУУС ХОРООЛОЛ

Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн бага өртөгтэй, эрэлт хэрэгцээнд тохирсон байр сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас “Залуус” хорооллыг барих ажлыг өрнүүлээд байна. “Залуус” хорооллын төслийн талбайд төрийн захиргааны байгууллага, олон нийтийн төв, мэдээлэл, технологийн кластер, эмнэлэг, сургууль, цэцэрлэг, хувийн хэвшлийн үйлчилгээ зэрэг 5,200 ажлын байр, зам, талбай, ногоон байгууламж, 5,616 айлын орон сууцыг холбогдох норм, стандартын дагуу цогц байдлаар төлөвлөсөн. Бүтээн байгуулалтын ажлыг инженерийн дэд бүтэц болон санхүүжилтийн эх үүсвэрээс хамааруулан үе шаттай хэрэгжүүлэхдээ иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн орон сууцыг санал болгоно.

Зураг 17. Залуус орон сууцны хороолол төсөл



5,616
өрх



Мэдээлэл
технологийн
төв



Нийгмийн
дэд бүтэц,
агаар хөрсний
бохирдол буурах



Эрүүл аюулгүй
орчин



Үйлчилгээний
газрууд

Залуус хороолол баригдсанаар зорилтот бүлгийн өрх, залуу гэр бүл орон сууцтай болно. Агаар, хөрсний бохирдол зохих хэмжээгээр буурах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ. Үйлчилгээний газрууд, нийгмийн дэд бүтэц, их дээд сургуулийн хотхон, мэдээллийн технологи, ИТ төв, төрийн зарим чиг үүргийн байгууллага зэргийг хороололд цогцоор нь байгуулна.



Эх сурвалж: Барилга, Хот Байгуулалтын Яам, 2021



ТОХИЛОГ АМЬДРАЛД ХӨТЛӨХ АРГА ЗАМ



Инженерийн хангамжийн төвлөрсөн эх үүсвэрээс зайтай гэр хорооллын дундын болон захын бүсийг хэсэгчилсэн инженерийн хангамжтай болгох зорилгоор "Бичил дэд төв" байгуулах боломжтой юм. Хэсэгчилсэн инженерийн хангамжийг гэр хорооллын бүсэд байгуулах ба амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэх боломж бүрдэнэ. Амины орон сууцны дундаж давхар 1-3 давхар байх ба эдэлбэр газартай блокчилсон (таун хаус), нийтийн эдэлбэр газартай, эдэлбэр газартай коттеж хэлбэрийн гэх мэт 3-4 төрөл байх ба үйлчилгээний төвүүдтэй, хатуу хучилт бүхий гудамж замын сүлжээ, ногоон байгууламж тохижилт сайтай бичил хороолол байдлаар төлөвлөгдөнө. Тухайлбал:

- Эдэлбэр газар бүхий тохилог амины орон сууцны тусдаа сууц (House)
- Эдэлбэр газар бүхий тохилог амины орон сууц (Townhouse)
- Тохилог амины орон сууц (Condo house)
- Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны хороолол

Зураг 18. Хэсэгчилсэн инженерийн хангамжтай "Бичил дэд төв"




Барилгын хэмжээ 16x12 м
Нийт талбай 576 м²

Дэд бүтцийн үйлчилгээ,
удирдлага хяналт байрлана.

- Газрын хэмжээ **2,794 га**;
- Төвлөрсөн инженерийн хангамжид холбох боломжгүй байршилд;
- Нэг Дэд бүтцийн төв нь **200-300 айл өрхийг** хангах;
- 50 ш бичил дэд төвийг барьснаар **10,000 янданг** бууруулах.

ДУЛААН ХАНГАМЖ



- Төвийн шугам сүлжээнд холбох
- Хатуу түлшний зуух
- Цахилгаан зуух
- Хийн түлшний зуух
- Газрын гүний дулаан

УСАН ХАНГАМЖ




- Төвийн шугам сүлжээнд холбох
- Гүний эх үүсвэр
- Зөөврийн эх үүсвэр

АРИУТГАХ ТАТУУРГЫН ХАНГАМЖ



- Төвийн шугам сүлжээнд холбох
- Бие даасан

ЦАХИЛГААН ХАНГАМЖ



- Төвийн шугам сүлжээнд холбох
- Бие даасан (сэргээгдэх эрчим хүч бүхий)

Эх сурвалж: Барилга, Хот Байгуулалтын Яам, 2021

АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ГАРААНЫ БИЗНЕС

ЗОРИЛТ 3.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Бичил, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үе



Хөдөлмөр нь оюуны болон биеийн хүчний ажлыг хамруулсан өргөн хүрээтэй ойлголт бөгөөд ажил эрхлэх чадамж гэж ойлгоно. Ажил эрхлэлтийг хөдөлмөрийн насны бүх хүний цалин хөлстэй юм уу, хуваариа эрхэлсэн хөдөлмөрийг нийтэд нь ойлгоно. Нөгөө талаас ажил эрхлэлт нь ажил олгогч, ажилтан хоёрын хооронд байгуулсан гэрээ хэлэлцээр буюу эрх зүйн харилцаа юм.


Нийгмийн даатгал, хамгааллыг бэхжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэх асуудал нь хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих; өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үндэсний улс орны эдийн засгийн өсөлтийг хангах; дэд бүтцийг сайжруулж, нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэлийг урамшуулах; иргэн төвтэй ухаалаг засаглалыг төлөвшүүлэх; төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах; хүн төвтэй хотыг бий болгох зэрэг хөгжлийн асуудлуудтай нягт уялдаатай.

Өнөөдөр нийт хүн амын 61.3 хувь хөдөлмөрийн насныхан буюу хүн амын цонх үе нээгдсэн ч тэдний 52.3 хувь нь л хөдөлмөр эрхэлж байна. Хүн амын цонх үе 2030 он хүртэл үргэлжлэх урьдчилсан тооцоолол бий.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох, жижиг дунд бизнес эрхлэлтэд таатай орчин бүрдүүлэх, гарааны бизнесийг дэмжих, нийгмийн оролцоог



Зураг 19. Ажиллах хүчний судалгаа (2022 оны I улирал)



хангах замаар тэдний амьдралын чанарыг дээшлүүлж, дундаж давхаргаа дээшлүүлэхийг зорьж байна.

2050 онд эдийн засгийн идэвхтэй хүн амыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, хөдөлмөрийн насны 10 иргэн тутмын 7-г нь ажиллах хүчний эгнээнд оруулах, ажилгүйдлийн түвшнийг гурав дахин бууруулахыг тус тус зорьж байна.

2021 оны IV улирлын байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 58.3 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 53.1 хувь, ажилгүйдлийн түвшин 8.5 хувьтай байна. Ажлын байр бий болгох, ажилчдын нийгмийн хамгааллыг сайжруулах, түр болон улирлын чанартай ажил эрхэлж байгаа хүмүүсийг нийгмийн даатгалд заавал хамруулах, шинээр хүүхэдтэй болсон гэр бүл, эцэг эхийг

Хөдөлмөрийн насны хүн амын ажиллах хүчний оролцоо 2022 оны I улирлын байдлаар 58.0 хувь буюу 1,232.9 мянга нь ажиллах хүч, үлдэх 42.0 хувь буюу 892.8 мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Энэ оролцооны түвшинг 2050 он гэхэд 70 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлээд байна.

АЖИЛЛАХ ХҮЧ

Цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүнийг ажиллах хүч гэнэ. Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж, ажиллах хүчний оролцооны түвшинг тооцно. Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ. Ажилгүйдлийн түвшинг тооцохдоо ажилгүй хүний тоог ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно.

Боломжит ажиллах хүчний бүлэг буюу ажлын байр бий болох, ажил хийх нөхцөл бүрдэх тохиолдолд ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа хүн ам юм. Энэ бүлгийн тоо хэмжээ нэмэгдэх нь хөдөлмөрийн зах зээл, ажлын байрны хүрэлцээгүй, ажиллах нөхцөлийн тогтвортой бус байдал, хөдөлмөрийн үнэлэмж сул байгаагийн илрэл болдог.


дэмжих зэргээр хувийн хэвшлээс гаргаж байгаа санаачилгыг дэмжихэд төр, иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг уялдуулах шаардлагатай. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн идэвхтэй хүн амын бүтээмжийг дээшлүүлэх бодлогоо шинэчилж, урт хугацаанд төлөвлөх шаардлагатай болсныг харуулна.

Бизнес регистрийн санд 2020 оны жилийн эцсийн байдлаар 96.0 мянган хуулийн этгээд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаагийн 63.2 мянга (65.8 хувь) нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байна. Эдгээр жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн 93.8 хувь нь 1-10 ажилтантай, 5.7 хувь нь 10-50 ажилтантай, үлдсэн 0.5 хувь 50-200 ажилтантай байна.

Дундаж давхаргын эгнээг тэлж, хамгаалахын тулд зохистой хөдөлмөр эрхлэлтийг бий болгон, цалин хөлсний түвшнийг нэмэгдүүлж, гарааны бизнес болон бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих ёстой. Иргэдийг өөрийгөө тэтгэн амьдрах боломжоор хангах нь хамгаас чухал байна. Тиймээс хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих цогц зорилтуудыг дэвшүүлсэн билээ.

Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ. Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд нь шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлж, орчин

Зураг 20. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлт



Эх сурвалж: ХНХЯ, 2021



нөхцөлийг бүрдүүлнэ. Малчин, тариаланчдын 75 хүртэлх хувийг өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник технологиор хангаж, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, тэдний бэлтгэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх оновчтой тогтолцоог бий болгоно. Ингэснээр бүтээмжтэй, зохистой ажлын байр бий болж, аж ахуй эрхлэлт нэмэгдсэнээр дундаж орлоготой иргэдийн тоо нэмэгдэнэ. Энэ нь амьдралын чанарыг сайжруулан нийгмийн дундаж давхаргыг өргөжүүлэх чухал ач холбогдолтой юм.

Жижиг, дунд үйлдвэрлэл ба гарааны бизнес МҮХАҮТ-ын судалгаанд хамрагдагсад бизнес шинээр эхлүүлэх, гарааны бизнес эрхлэгчдэд тулгамддаг асуудал буюу шинэ бизнес эрхлэхэд тулгардаг нийтлэг хүндрэлийг тодорхойлоход хүнд суртал, авлига, шаардлагатай баримт бичгийн тоо их зэрэг нь хүндрэлтэйгээс гадна бизнесээ эхлүүлэх үйл явцад шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, эхлэлийн хөрөнгө, гарах зардал нь хүндрэлтэй асуудлын тоонд багтжээ. Харин бизнесээ эрхлэхэд хамгийн их шаардлагатай дэмжлэг нь бизнесийн зээлийн хүүг бууруулах, зээлийн нөхцөлийг сайжруулах, татварын таатай орчин бүрдүүлэх, хууль эрх зүйн орчин сайжруулах, авлига, хүнд суртлыг бууруулах асуудлыг нэн тэргүүнд ач холбогдолтой гэж үзэж байна.

Жижиг дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Инновац технологи нэвтрүүлэх, мэдлэг хуваалцах чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн нөхцөл бүрдэж, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон, зах зээлд нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлснээр бичил, жижиг, дунд бизнес олон улсад өрсөлдөх боломжтой болох юм.

БИЗНЕСЭЭ ШИНЭЭР ЭХЛҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

0-10 Онооны үнэлгээгээр


- 2.17** Шаардагдах хөрөнгийн эх үүсвэр
- 2.35** Гарах зардал
- 2.78** Зарцуулах хугацаа
- 3.03** Бизнесээ бүртгүүлэх үйл явц

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ АВАХ ҮЙЛ ЯВЦ

0-10 Онооны үнэлгээгээр

- 2.26** Хүнд суртал
- 2.31** Авлигал, хээл хахууль
- 2.32** Шаардлагатай гарын үсгийн тоо
- 2.35** Зарцуулах хугацаа
- 2.36** Шаардлагатай баримт бичгийн тоо
- 2.50** Хууль дүрэм стандартын нийцэл
- 2.44** Шинэ бизнес эрхлэхэд тулгардаг нийтлэг хүндрэл

Зураг 21. Нийт эдийн засгийн болон бизнесийн секторын хөдөлмөрийн бүтээмж мянган төгрөг, 2015-2020



Эх сурвалж: YCX, 2021

НЭГ СУУРИН-НЭГ БҮТЭЭГДЭХҮҮН САНААЧИЛГА

1980-аад онд хамгийн анхны “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” (НСНБ) санаачилга, хөдөлгөөн Япон улсын Ойта мужид өрнөжээ. Тухайн үед мужийн эдийн засгийн чадавх сул, хангалттай ажлын байр байхгүйгээс хүн амын дийлэнх хэсэг нь хот суурин газар руу шилжих хөдөлгөөн даамжирсан зэрэг нийгмийн асуудлууд энэхүү шинэ хөдөлгөөн үүсэх үндсэн суурийг тавьсан байна. Нөхцөл байдалтай уялдуулан суурин дахь нийт өрхийн үндсэн орлого болох хүнсний ногоо, жимс жимсгэнийг муж дотроо дахин боловсруулж савлан, нэмүү өртөг шингээн, түүнийгээ зах зээлд гаргах замаар өрхийн ашиг орлогыг нэмэгдүүлээд зогсохгүй ажлын байр ч нэмэгдэж, муж даяараа эдийн засгийн хүнд нөхцөлөөс гарч чаджээ. Энэхүү хөдөлгөөний үр дүнд Ойта муж нь жилд 140 тэрбум иенийн 336 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн зах зээлд гаргахуйц хүчин чадалтай болсон байна. “НСНБ” нь Япон улсын муж болгонд биеллээ олоод зогсохгүй хөгжиж буй 60 гаруй орон ч энэ туршлагыг өөрийн орон нутгийн засаг захиргаандаа хэрэгжүүлэх болжээ.

Эх сурвалж: Удирдлагын академи, 2022

Монгол Улсын өнцөг булан бүрд хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн цогц бодлого хэрэгжүүлнэ.

Аймаг, сумдын нөхөрлөл, хоршоо, гэр бүлийн болон хувийн бизнес эрхлэлтийг санхүүгээр дэмжиж, зах зээлд холбох арга хэмжээг хэрэгжүүлнэ. Өртгийн сүлжээний кластер байгуулж, ажлын байр бий болгох төслүүдийг улс, аймгийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд холбоно. Жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, нийтийн өмчийн хадгалалт борлуулалтын цогцолбор байгуулна. Орон нутгийн иргэдийн бие даасан, бүтээлч байдлыг дэмжих зорилгоор “Нэг суурин-нэг бүтээгдэхүүн” аяныг сум бүрд зохион байгуулна.

Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, малчин, тариалан эрхлэгчид, ногоочдын аж ахуй эрхлэх газрыг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох юм.

Уламжлалт мал аж ахуй, газар тариаланд түшиглэсэн жижиг, дунд бизнесийг орон нутагт хөгжүүлж, бэлэн бүтээгдэхүүний борлуулалтад дэмжлэг үзүүлснээр иргэдийн амьдралд мэдэгдэхүйц ахиц гарна. Ингэснээр хөдөөд хөгжил очиж, хотыг чиглэсэн их нүүдэл ч саарах сайн талтай. Илүү өргөн хүрээгээр авч үзвэл дэлхийн зах зээлд Монголын брэнд бүтээгдэхүүнийг таниулж, экспортын шинэ гарц, чиглэлтэй болох юм. Хамгийн чухал нь хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, ажилтай орлоготой иргэд



Зураг 22. Бизнес эрхлэх орчныг сайжруулахад шаардлагатай арга хэмжээ (судалгааны үр дүнгээс)



ЭХ СУРВАЛЖ: Монголын Үндэсний Худалдаа
Аж үйлдвэрийн Танхим, 2020

нийгэмд зонхилж эхэлнэ. Ингэснээр халамжаас хөдөлмөрт чиглэсэн төрийн бодлого хэрэгжиж, дундаж давхарга зонхилсон нийгмийг бүтээх биеллээ олно.

Бизнес эрхлэх орчныг сайжруулахын тулд татварын дарамтыг багасгах оновчтой бодлогоор хөнгөлөлт үзүүлэх, зээлийн хүүг бууруулах, зээлийн хэмжээнд уян хатан хандах, банк санхүүгийн байгууллагын зээлийн үйлчилгээний үйл явцыг хялбаршуулах, дотоод хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, авлига, хээл хахууль, хүнд суртлыг арилгах, эдийн засгийн таатай орчныг бий болгох асуудалд төр засаг гол анхаарлаа хандуулах шаардлагатай учир гарааны бизнесийг дэмжих зорилтыг дэвшүүлсэн. Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх дэд бүтцийг хөгжүүлэх юм. Ингэж дэд бүтэц бүрдүүлсний дараа гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, санхүүгийн үр ашигтай тогтолцоог бий болгоно.

Үндэсний томоохон болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бичил, жижиг бизнестэй холбож, ханган нийлүүлэлтийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. Мөн төрийн худалдан авалтаар гарааны, жижиг, дунд бизнесийг дэмжинэ. Төр холбогч гүүр болоод зогсохгүй худалдан авагч болж, гарааны, бичил, жижиг, дунд бизнесийг дэмжигч болох юм.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль хэрэгжиж эхэлсэнээр ХУВИЙН ХЭВШИЛД бий болох боломжууд:

- ✓ Бизнесийн шинэ зах зээл нээгдэх боломж бий болно.
- ✓ Гадаад зах зээлээс хөрөнгө оруулалт татах боломж бүрдэнэ.
- ✓ Урт хугацаанд тогтвортой бизнестэй болох боломжууд бүрдэнэ.

Мөн том аж ахуйн нэгж, төрийн худалдан авалтын гэрээг үндэслэн гарааны, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зээлийн барьцаа шаардахгүйгээр зээл олгох нөхцөлийг бүрдүүлнэ. Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, аж ахуйн нэгжүүдэд илүү олон боломжийг нээнэ.

Хүсэл тэмүүлэл, ур чадвар, зорилгыг дэмжихээс эхлээд мэргэшүүлэх, санхүүгээр дэмжих, хүний нөөцийг бэлдэх, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, бэлэн бүтээгдэхүүнийг худалдан авах, том аж ахуйн нэгжүүдтэй холбож зуучлагч болох гээд төрөөс хамаарах бүхнээр төр бизнесийг дэмжигч, хөгжүүлэгч болно гэсэн үг.

Хөдөлмөр эрхлэлт, гарааны, жижиг, бичил, дунд бизнесийг дэмжих нь нийгэм, эдийн засгийн олон талын ач холбогдолтой. Шинээр ажлын байр бий болж, иргэд орлоготой болсноор амьдралын чанар нь дээшилнэ. Бизнес эрхлэгчид татвар, төлбөр, хураамжаар улсын эдийн засагт орлого төвлөрүүлж, тэлэх боломжийг нээнэ. Цаашлаад импортыг орлох бүтээгдэхүүнүүдийг эх орондоо үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээгээ хангана. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого зөвхөн хүний асуудал биш, улс орны нийгэм, эдийн засгийн чухал бүрэлдэхүүн хэсэг билээ.

ГАРААНЫ БИЗНЕС (СТАРТАП) ГЭЖ ЮУ ВЭ?

Стартап компани гэдэг нэр томъёо нь өнгөрсөн зууны сүүлээр Цахиурын хөндийд үүссэн технологид суурилсан интернэт компаниуд олноороо төрөн гарч эхэлсэн үеэс үүдэлтэй. Эдгээр компаниудын онцлог нь технологиор өрсөлдөн, интернэтийн зах зээлд нэвтрэн үйлчлүүлэгчдэд бүтээгдэхүүнээ хүргэн олон тэрбум ам.долларын ашиг олох болсон нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг маш ихээр татаж эхэлсэн юм. Мэргэжилтнүүдийн тодорхойлсноор:

- **Өргөжин тэлэх** Стартап гэдэг нь тасралтгүй үргэлжлэх, цаашид өргөжин тэлэх боломжтой бизнес загварыг хайхаар загварчлагдсан шилжилтийн үеийн байгууллага.
- **Өсөж хөгжих** Стартап компанийн бизнес модел нь тасралтгүй үргэлжлэх буюу дахин дахин давтагдахуйц байх шаардлагатай. Ингэж байж цаашид үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлнэ.
- **Дэвжих** Стартап компаниуд хөрөнгө оруулагч нарын хөрөнгийг нь өсгөхийн тулд өсөн дэвжих боломжтой байх шаардлагатай. Ийм амлалтаар хөрөнгө оруулагчдын итгэлийг олох болно.
- **Байр сууриа батлах** Стартап компанийн зорилго цаашид өсөн дэвжээд том компани болоход чиглэсэн байдаг.

Эх сурвалж: Удирдлагын академи, 2022



НОРВЕГИ УЛСЫН ТУРШЛАГА



Жижиг, дунд үйлдвэрлэлээр дамжуулан дундаж давхаргаа тэлж чадсан Норвеги улсын нийт аж ахуйн нэгжийн 99 хувийг жижиг, дунд бизнес эзэлдэг. Мөн нийт ажлын байрны 73.7 хувийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид бүрдүүлдэг. Тийм ч учраас баялгийн үнийн хэлбэлзэл, дуулиант эдийн засгийн хямралд Норвеги улс төдийлөн өртдөггүй.

Тус улсын дотоодын зах зээл нь манай улстай адил жижиг. Тэд энэ онцлогоо харгалзан бүх үйлдвэрлэлээ байгалийн нөөц болон бараа бүтээгдэхүүнийг боловсруулан экспортлоход чиглүүлсэн байна. Үйлдвэрлэсэн байгалийн хийнийхээ зөвхөн таван хувийг өөрсдөө хэрэглэдэг аж. Нефть, байгалийн хий, хөнгөн цагаан, ферро хайлшны Европ дахь гол нийлүүлэгч болсноос гадна дэлхийн бүх үнэт цаасны 1.4 хувийг эзэмшдэг. Үүгээр зогсохгүй дэлхийн 140 оронд загас нийлүүлж, тэмээн хяруулын хамгийн том экспортлогч орон болж чаджээ. Энэ нь хувийн бизнес эрхлэгчдээ дэмжсэн бодлоготой холбоотой. Хувийн бизнес хийхийг хүсэгчид төрөөсөө хөнгөлөлттэй зээл авах боломжтой. Бизнес нь хөл дээрээ бостол татвар төлөх шаардлагагүй. Жижиг, дунд бизнес эрхлэгчид дампуурна гэсэн ойлголт байдаггүй. Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бичиг баримтаа бүртгүүлэхэд амар хялбар, лиценз бүртгэл татварын баримт бүрдүүлэлтийн төлбөр нь дэлхийд хамгийн хямд. Норвеги улс нь дэлхийд хамгийн авлигагүй 10 орны нэг. Байгалийн баялгаас орсон орлогоо Норвеги улс хөгжлийн санд төвлөрүүлдэг байна.

НОРВЕГИЙН ХӨГЖИЛ

Норвегийн Засгийн газрын тэтгэврийн сан нь Норвегийн засгийн газрын мэдэлд байдаг хоёр тусдаа бие даасан баялгийн сангаас бүрддэг.

Засгийн газрын тэтгэврийн сан нь 1990 онд Норвегийн газрын тосны салбарын илүүдэл орлогыг удирдах зорилгоор байгуулагдсан. Одоогоор 1.35 их наяд ам.долларын хөрөнгөтэй бөгөөд дэлхийн хөрөнгийн биржид бүртгэлтэй бүх компаниудын 1.4 хувийг эзэмшдэг дэлхийн хамгийн том баялгийн сан болж байна.

2021 оны арванхоёрдугаар сарын байдлаар Норвегийн иргэн бүрд 250,000 орчим ам.долларын сангийн хөрөнгө ногдож байсан. Үл хөдлөх хөрөнгө болон тогтмол орлоготой хөрөнгө оруулалтын багцыг эзэмшдэг.

70 УЛС ОРОН

Норвегийн газрын тосны сан нь дэлхийн хамгийн том сангуудын нэг юм. Энэ төрлийн хөрөнгө оруулалт нь дэлхийн улс орнуудын зах зээлийг хамарсан.

9,338 КОМПАНИ

Энэхүү сан нь дэлхий даяар нийт 9,000-аас их компаниудтай хамтарч ажилладаг. Apple, Nestle, Microsoft, Samsung дунджаар энэ санд нийт компаниудын 1.3 хувийг багтаадаг.

4 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БУСҮҮД

Сангийн ихэнх нь хамтран ажилладаг байгууллагуудынхаа хувьцаанд хөрөнгө оруулалт хийдэг. Өөр нэг хэсэг нь засгийн газартаа, үлдсэн нь үл хөдлөх хөрөнгө, дэд бүтэц, сэргээгдэх эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалт байдаг.

АМЬДРАЛ ТЭТГЭХ ЖИЖИГ ДУНД БИЗНЕС



Бизнесийн хөнгөвчлөх үйлчилгээ, бойжуулах инкубаторуудыг хөгжүүлснээр жижиг дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны өртөг зардал буурч, улмаар өрсөлдөх чадвар нэмэгдэх юм. Ингэснээр бүтээмжтэй, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдлыг хөхиүлэн дэмжиж, тэгш бус байдлыг багасгаж, нийгмийн дундаж давхарга тэлнэ. Өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн инновац, технологи нэвтрүүлэх, мэдлэг хуваалцах чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, экспортын зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх юм. Энэ нь бичил, жижиг, дунд бизнес олон улсад өрсөлдөх боломжийг олгоход чухал ач холбогдолтой.

Зураг 23. Жижиг, дунд бизнесийг дэмжих арга хэмжээ



ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ
ЭРХЛЭХ ЭРХ ЗҮЙ, БИЗНЕСИЙН
ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ



САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫГ
САЙЖРУУЛАХ ЗАМААР ЗЭЭЛИЙН ХҮҮГ
БУУРУУЛАХ, ХУГАЦАА УРТАСГАХ, САНХҮҮГИЙН
ХӨНГӨЛӨЛТТЭЙ НӨХЦӨЛ БИЙ БОЛГОН,
ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ



ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨХИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ, ДЭМЖИХ ЗАМААР
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ



ИННОВАЦ БОЛОН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН
НЭВТРҮҮЛЭЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭН, СТАНДАРТЫН
ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ



ЖИЖИГ, ДУНД
ҮЙЛДВЭРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ
ӨРГӨТГӨХ, БОРЛУУЛАЛТАД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ



“НЭГ СУУРИН-НЭГ БҮТЭЭГДЭХҮҮН” АЯНЫГ
ЗОХИОН БАЙГУУЛЖ, ОРОН НУТАГТ БРЭНД
БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БИЙ БОЛГОХ, ЖИЖИГ, ДУНД
ҮЙЛДВЭР ЭРХЛЭГЧИЙН БИЕ ДААСАН, БҮТЭЭЛЧ
БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ




ЧАНАРТАЙ АМЬДРАЛД ХӨТЛӨХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



Үндэсний томоохон болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бичил, жижиг, дунд бизнестэй холбож, ханган нийлүүлэлтийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. Мөн гарааны бизнесийг дэмжихэд чиглэсэн бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд төрийн худалдан авалтаар гарааны, жижиг, дунд бизнесийг дэмжинэ. Ингэснээр төр холбогч гүүр болоод зогсохгүй худалдан авагч болж, гарааны, бичил, жижиг, дунд бизнесийг дэмжигч болох юм.

Зураг 24. Гарааны бизнесийн орчин



АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

ДУНДАЖ ДАВХАРГЫГ ДЭМЖСЭН САНХҮҮЖИЛТ

ЗОРИЛТ 3.4 Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлж, эрсдэлээс хамгаална.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ · ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Дундаж давхаргыг бэхжүүлэх үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Дундаж давхаргыг тэлж, санхүүгийн эрсдэлээс бүрэн хамгаалах үе

... ᠠᠯᠤᠰᠤᠨ ᠬᠠᠷᠠᠳ 2050 ...
ᠳᠤᠨᠳᠠᠵᠢ ᠳᠠᠪᠬᠠᠷᠭᠢᠭᠢᠨ ᠴᠢᠭᠢᠯᠡᠰᠢᠨ ᠰᠠᠨᠬᠡᠭᠦ᠋᠎ᠠᠶᠢᠨ ᠦ᠋ᠶᠢᠯᠴᠢᠯᠢᠭᠡᠢ ᠦ᠋ᠰᠦᠳᠡᠯᠡᠭᠡᠰ ᠬᠠᠮᠭᠠᠯᠠᠭ ᠦ᠋ᠰᠡᠭᠡᠢ ᠦ᠋ᠰᠡᠳᠡᠯᠡᠭᠡᠰ ᠬᠠᠮᠭᠠᠯᠠᠭ ᠦ᠋ᠰᠡᠭᠡᠢ

Эдийн засагчид дундаж давхаргыг тодорхойлохдоо орлогын үзүүлэлтийг голлодог бол нийгмийн салбарын бусад судлаачид орлогоос гадна иргэдийн хөрөнгө чинээ, амьдралын сэтгэл ханамж, санхүүгийн болон тэтгэврийн үеийн аюулгүй, эрсдэлгүй байдал, боловсрол, эрүүл мэнд зэрэг асуудлыг хамруулдаг байна. Улс орнууд дундаж давхаргыг өргөжүүлэх нь эдийн засгийг хөгжүүлэх хурдасгуур болно гэж үздэг.


Манай орны хувьд 2020 онд ядуурлын хамралт улсын хэмжээнд 27.8 хувь байгаа бол нийт хүн амын 14.4 хувь нь ядуурлын шугамаас дөнгөж дээгүүр амьдарч байна.

Энэ нь эдийн засгийн гэнэтийн хямралт үйл явдал тохиолдвол түүний нөлөөгөөр дээрх бүлэгт хамаарах хүмүүс ядууралд өртөж, ядуурлын түвшнийг огцом нэмэгдүүлэх эрсдэлтэй байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл дундаж давхаргын бүлэг эрсдэл тулгарахад ядуурлын түвшин рүү шилжих аюултай. Иймээс дундаж давхаргыг дэмжих эрсдэлээс хамгаалсан санхүүгийн үйлчилгээг үзүүлэх нь дундаж давхаргын бодлогын бас нэг арга хэмжээ болно.

Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлнэ. Энэ хүрээнд зорилтог санхүүжилт, хөнгөлөлт, хүртээмжтэй үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх юм.



Зураг 25. Өрхийн сарын дундаж орлого



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2022

Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн өрх, гэр бүлд ээлтэй банк, санхүүгийн үйл ажиллагааг тогтворжуулж, олон улсын жишигт нийцүүлэх, эрсдэлээс хамгаалах бодлого хэрэгжүүлж, өрх, гэр бүл өөрийгөө тэтгэн амьдрах боломжийг бүрдүүлэхийг зорьж байна.

Дундаж давхаргаа санхүүгийн хөшүүргээр дэмжиж, хүрээг нь тэлэхийн тулд банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах шаардлага үүснэ. Дундаж давхарга тэлэх тусам боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээ хүртээмжтэй, ажиллах хүчин сайтай, хөдөлмөрийн бүтээмжтэй, түүнийг дагаад ашиг, орлогын хэмжээ өндөр байдаг тул тэдний оруулж буй хувь оролцоо нь тэр хэрээр улсын эдийн засгийн өсөлтөд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Банк санхүүгийн байгууллагууд улсын эдийн засгийн хөгжил, дэвшлийг хангах нийгмийн хамгийн идэвхтэй энэхүү хэсэгт зорилтот үйлчилгээ үзүүлэх гарцаа олдог. Тэд дундаж давхаргад зориулсан санхүүгийн зөвлөгөө өгөх инкубатор бизнес төвүүдийг байгуулж, дундаж давхаргад зориулсан санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс гадна дундаж давхаргын хуримтлалын хадгаламж, тэтгэвэрийн сан хадгаламж, эрүүл мэндийн хадгаламж, аяллын хадгаламж болон бусад санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэдэг. Мөн Бичил бизнесийн зээл, жижиг бизнес эрхлэгчийг дэмжих зээл, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зээл, гарааны бизнесийг дэмжих зээл, сургалтын төлбөрийн зээл, гялс зээл, санхүүгийн түрээс, орон сууцны хөнгөлөлттэй зээлүүдийг хамгийн таатай нөхцөлөөр олгодог.

Тухайлбал, Төрийн банк дундаж давхаргыг дэмжих цогц төлөвлөгөөндөө хуримтлалтай дундаж давхаргыг дэмжих зорилтын хүрээнд орон нутгийн иргэд, малчдад зориулсан хөнгөлөлттэй, хугацаатай хадгаламжийн үйлчилгээ зах зээлд нэвтрүүлжээ.

Зорилготой, зорилттой санхүүгийн үйлчилгээ

Бичил, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх зээлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх замаар эрэлтэд нийцсэн, итгэлцэлд суурилсан, зорилтот хөнгөлөлттэй, хүртээмжтэй зээлийн бүтээгдэхүүнүүдийг бий болгож, хамгийн таатай нөхцөлөөр олгоно.

Банк, санхүүгийн байгууллагын санаачилгад түшиглэнэ

Банк, санхүүгийн байгууллагуудын жижиг, дунд бизнес эрхлэгчид, дундаж давхаргын иргэдэд зориулсан бага хүүтэй, барьцаа хөрөнгө шаардахгүй, урт, богино хугацаа, уян хатан нөхцөлтэй зээл, дараа төлбөртэй санхүүгийн үйлчилгээний төрөл бүрийн санал санаачилгыг дэмжсэнээр энэ чиглэлийн үйл ажиллагаа эрчимжиж, зохих үр дүнд хүрнэ.

Энэхүү хадгаламж нь орон нутгийн иргэд малчдын өрхийн бүтээмж, эдийн засгийн чадамжаа нэмэгдүүлэх, хадгаламжийн хүүгээр мөнгөө өсгөх болон сар бүр хадгалуулсан мөнгөндөө бодогдсон хүүг авч хэрэглээндээ зарцуулах боломжийг олгодог дараах давуу талуудтай

- Хадгаламжийн хүүгээ дансандаа болон картандаа авах: Хадгаламжийн хүүгээ сар бүр тооцуулж, үндсэн хадгаламждаа нэмэгдүүлэн хүүгийн хүү авах эсвэл хүүгээ картандаа авч ашиглах сонголттой.
- Гэрээний хугацаанд нэг удаа зарлага гаргах: Мөнгөн хадгаламжаа гэрээний хугацаанд нэг удаа хүү бууруулахгүйгээр зарлага гаргах боломжтой.
- Орон нутгийн иргэд, малчдын хувьд банкаараа хувийн санхүүгийн гүйлгээг хийхээс гадна цаг агаарын онц ноцтой үзэгдлийн мэдээ, мэдээллийг цаг алдалгүй түргэн шуурхай хүлээн авч эрсдэлээс хамгаалагдах боломжтой.
- Банкны брэнд картын эхний жилийн хураамжаас чөлөөлөх: Мөнгөн хадгаламж байршуулсан хугацаа болон орлогын дүнгээс хамааран олон улсын картыг эхний жилийн хураамжаас чөлөөлүүлэн авах боломжтой.
- Малчны зээлийг хүүний хөнгөлөлттэй нөхцөлөөр авах: Тус хадгаламжийг эзэмшсэнээр малчны зээлийн бүтээгдэхүүнийг хүүний хөнгөлөлттэй нөхцөлөөр авах боломжийг олгож байна.

Энэ хүрээнд Засгийн газраас баталсан 10 их наядын цогц төлөвлөгөөний дагуу малчдыг дэмжсэн, хаврын тариалалт, ноолуур бэлтгэлийн зээлийн бүтцийг Монголбанкттай хамтран арилжааны банкаар дамжуулан хэрэгжүүлсэн байна.

Зураг 26. Эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөр хөдөө аж ахуйн салбарт

10 их наядын цогц хөтөлбөрийн хөдөө аж ахуйн дэд хөтөлбөр





Зураг 27. Өрхийн зээлийн мэдээлэл

НИЙТ ЗЭЭЛТЭЙ ӨРХИЙН ЗЭЭЛИЙН ТӨРӨЛ



ЦАЛИНГИЙН ЗЭЭЛ
218.1 (44.4%)
мянган өрх



ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ
106.9 (21.8%)
мянган өрх



БУСАД ТӨРЛИЙН ЗЭЭЛ
153.7 (31.3%)
мянган өрх



ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛ
78.1 (15.9%)
мянган өрх



ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛ
50.9 (10.4%)
мянган өрх

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2022

Иргэдэд зориулсан санхүүгийн олон үйлчилгээг бий болгох нь чухал. Тухайлбал, итгэлийн зээл, урьдчилгаагүй лизинг зэргээр уян хатан нөхцөлтэй зээлийн үйлчилгээ бий болгож, бичил, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэхийн тулд эрэлтэд нийцсэн зээлийн шинэ бүтээгдэхүүнийг гаргах зэргээр дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилтийг бий болгоно.

Бизнес эрхлэх сонирхолтой иргэдэд зээлийн хүрэлцээ бага, хүү өндөр, барьцаа хөрөнгө байхгүй зэрэг хүндрэл тулгардаг. Тиймээс бага хүүтэй, барьцаа хөрөнгө шаардахгүй, санхүүгийн уян хатан нөхцөлтэй бага дүнтэй зээлийг зорилтот бүлгийн иргэдэд хүргэх зорилгоор Итгэлийн зээл бий болгох эрх зүйн орчин бүрдүүлнэ.

Албан салбарт хөдөлмөр эрхэлж буй иргэдээс гадна хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй малчин, тариаланчид, хувиараа жижиг дунд бизнес эрхлэгчдэд ч санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Өдгөө малчдад олгож буй ноос, ноолуурын мөнгөнөөс гадна санхүүгийн шинэ төрлийн үйлчилгээнүүдийг ч бий болгох боломжтой.

Цаашдаа бага, дунд орлоготой өрхийн хүүхдүүдийг шинжлэх ухаан, технологи, инженер, математикийн боловсрол эзэмшихэд зориулсан тэтгэлэг бий болгож, дэмжлэг үзүүлнэ. Тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл гаргах замаар тухайн гэр бүлийн санхүүгийн дарамтаас чөлөөлөхөөс гадна хүүхдүүдэд сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлнэ. Дундаж давхаргад зориулсан хөрөнгө оруулалтыг энэ тогтолцоонд үндэслэн хийх бөгөөд энэ нь тэднийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах нэг арга зам болж байна.

““


Бага, дунд орлоготой айл өрхийн хүүхдүүдэд шинжлэх ухаан, технологи, инженер, математикийн боловсрол эзэмшихэд зориулсан тэтгэлэг бий болгох нь ирээдүйн дундаж давхаргыг иргэдийн боловсролд хөрөнгө оруулж буй хэлбэр юм.

””

ДУНДАЖ ДАВХАРГЫГ ДЭМЖИХ САНХҮҮГИЙН ТОГТОЛЦОО

Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн өрх, гэр бүлд ээлтэй банк, санхүүгийн үйл ажиллагааг тогтворжуулж, олон улсын жишигт нийцүүлэн хөгжих, эрсдэлээс хамгаалах бодлого хэрэгжүүлж, өрх, гэр бүл өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой болно.

Зураг 28. Дундаж давхаргыг дэмжих санхүүгийн тогтолцоо





УЯН ХАТАН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН



Бичил, жижиг дунд бизнесийг хөгжүүлэх зээлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, төрөлжүүлэх замаар итгэлийн зээл, лизинг зэрэг эрэлтэд нийцсэн санхүүгийн шинэ төрлийн олон хэлбэрийн үйлчилгээг бий болгох юм. Олон улсын туршлагад үндэслэн зээлийн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр банк, санхүүгийн байгууллагатай хамтарч ажиллана.

Зураг 29. Олон улсад өргөн хэрэглэгддэг бизнесийн зээлийн төрлүүд

ОЛОН УЛСАД ӨРГӨН ХЭРЭГЛЭГДДЭГ БИЗНЕСИЙН ЗЭЭЛИЙН ТӨРЛҮҮД



Эргэлтийн
хөрөнгийн
зээл



Хугацаатай
зээл



Хадгаламж
барьцаалсан
зээл



Гарааны
зээл



Аккердатов



Машин
механизмын
зээл



Төлбөр/
нэхэмжлэлийн
хөнгөлөлт



Явж байгаа
машины зээл



Бичил зээл



Тоног
төхөөрөмжийн
санхүү



Худалдааны зээл



Засгийн ЖДҮ-ийн
сангийн зээл



Худалдааны бэлэн
мөнгөний урьдчилгаа

АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ

ЗОРИЛТ 3.5 Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030


Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэнийг төлөвшүүлэх биеийн тамир, спортын чанар, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Биеийн тамир, спортын идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүл төлөвших үе



Эрүүл биед саруул ухаан оршино. Тиймээс монгол хүн бүрийг эртэч, эрүүл, идэвхтэй амьдралын дадалтай болгохыг зорьж байна.

Өглөө эртлэн босдог, ажилдаа яардаг, эрүүл мэнддээ анхаардаг, өндөр цалинтай үндэстэн болохын тулд бид амьдралын дадал хэвшилд соёлын өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай тулгарч байна.

Биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгож, иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн идэвхтэй амьдралын дадал хэвшил төлөвшүүлэх насан туршийн боловсролын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлдэг олон улсын туршлага бий. Өнөөдөр Монгол улсад хүн амын дунд илүүдэл жинтэй биеийн жингийн илүүдлээ тооцох, амьдралын зөв дадал хэвшил дутмаг байна.

Манай улсад 15-69 насны хүн амын 21.9 хувь нь хөдөлгөөний хомсдолтой, 52.4 хувь нь ажлын байрандаа, 48.2 хувь нь амралт чөлөөт цагаараа эрүүл мэндэд тустай идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй, мөн идэвхгүй, суугаа байдалд хоногт дунджаар 3.4 цагийг зарцуулдаг бөгөөд 49.4 хувь нь илүүдэл жин ба таргалалттай байна (Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын үндэсний судалгаа, ЭМЯ, НЭМҮТ, ДЭМБ, 2019 он, Монгол улс).

Монголчууд өдөрт дунджаар 2,737 алхам алхдаг ба 18-69 насны нийт хүн амын 29.2 хувь нь өдөрт 3,000-10,000, 24.6 хувь нь 3,000-



аас доош, дөнгөж 4.9 хувь нь ДЭМБ-ын зөвлөмжийг биелүүлж, 10,000-аас дээш алхам алхдаг байна. Дэлхийд хөдөлгөөний хомсдолоос үүдэлтэй өвчлөлөөр жилд дунджаар 3.2 сая хүн нас бардаг. Хөдөлгөөний хомсдол нь зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин зэрэг халдварт бус өвчний гол шалтгаан болдог.


Техник технологийн хурдацтай хөгжил, дэвшил нь энерги зарцуулах хэрэгцээг багасган, суугаа амьдралын хэв маягийг бий болгож байна. Мөн дэлхийд гурван хүн тутмын нэг нь хөдөлгөөний хомсдолтой байдаг бөгөөд ДЭМБ-ын гишүүн орнууд 2025 он гэхэд нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болсон хөдөлгөөний хомсдолыг 10 хувиар бууруулах зорилт тавин ажиллаж байна.

Чихрийн шижин, цусны даралт ихсэх, тархинд цус харвах, судас хатуурах, зүрхний шигдээс, элэг өөхлөх, хатуурах, ясны сийрэгжилт, цөс чулуужих, нойр булчирхайн үрэвсэл, ходоод сунах, шархлах, бодисын солилцооны хам шинж, хавдар гэх мэт маш олон өвчний шалтгаан, эрсдэлт хүчин зүйл болж байна. Зарим нэг судалгааны тоо баримтаас дурдвал, биеийн жингийн индекс 25 ба түүнээс дээш хүмүүс чихрийн шижин өвчнөөр

Хариуцлага

Эрүүл мэнд бол бидний ирээдүйдээ хийх хөрөнгө оруулалт бөгөөд нийгмийн эрүүл мэндийг хангах асуудал бол нийтийн хариуцлага, ухамсрын болон ёс зүйн үүрэг юм.

Зураг 30. Эрүүл амьдрахуй



Сургамж

Цар тахал, нийтийг хамарсан өвчин, нийгмийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй аливаа нөхцөл байдалд цаг алдахгүй, шуурхай арга хэмжээ авах, зохион байгуулалтад орох, бэлэн байдлыг хангах олон нийтийн дунд тогтворгүй, ойлгомжгүй байдал үүсгэхгүйн тулд нийтлэг стандарт тогтоон, байнгын бэлэн байдалд ажиллах шаардлагатай.

хэвийн жинтэй хүнээс ес дахин их, биеийн жингийн индекс 30 ба түүнээс дээш бол 40 дахин ихээр өвчилдөг байна.

Таргалалтаас болж шууд нас барах нь ховор боловч таргалалтын улмаас үүсэх өвчний хүндрэлээр нас барах нь их байна. ДЭМБ-ын дүгнэлтээр биеийн жин 10 хувиар нэмэгдэхэд эрэгтэйчүүдийн 11 хувь, эмэгтэйчүүдийн долоон хувьд нас баралт нэмэгддэг гэсэн байдаг. Таргалалттай хүмүүсийн нас баралтыг эрүүл хүмүүстэй харьцуулахад тархинд цус харвалт дөрөв дахин их, зүрхний шигдээсээр нас баралт тав дахин их байна. Иймээс илүүдэл жин таргалалттай хүмүүсийн дундаж наслалт 7-12 жилээр бага байдаг.

Олон улс идэвхтэй амьдралын хэв маягт эрүүл мэнд, зөв хооллолт, хөгшрөлтийн үйл явцыг удаашруулах зэрэг асуудлыг оруулж байна.

1. Эрүүл мэнд. Хүн өдөр тутмын амьдралдаа эрүүл мэндийг анхаарах асуудлыг дадал хэвшил болговоос зүрх судасны өвчин, хорт хавдар, таргалалт, чихрийн шижин, амьсгалын замын зэрэг олон өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжтой. Энэ нь эргээд урт удаан амьдрах, дархлааны системийг сайжруулах, зөв зүйтэй аж төрөхөд тустай
2. Зөв хооллолт. Эрүүл амьдрахад шаардлагатай шим тэжээлийг хоол хүнснээс өөрийн биед шингээн авах нь эрүүл мэндийн хамгийн чухал хүчин зүйлсийн нэг юм. Чанартай хооллолт гэдэг нь эрүүл, идэвхтэй амьдрахад шаардлагатай төрөл бүрийн шим тэжээлийг хангалттай хэмжээгээр агуулсан олон төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хүнсний бүтээгдэхүүний хэт их хэрэглээг хязгаарлахыг хэлнэ. Хүнсний хэрэглээний олон талт болон тэнцвэртэй байдал нь эрүүл хооллолтод чухал ач холбогдолтой.

ЭРТЭЧ ҮНДЭСТЭН

Азийн улс орнууд ялангуяа Хятад, Солонгос улс орны өглөө эртлэн босож ажлаа эхлүүлдэг жишгийг дэлхий нийтэд харуулаад үндэсний соёлын хэм хэмжээ болгожээ. Монголчууд "эрт босвол нэгийг үзэж, орой унтвал нэгийг сонсоно" гэж сургадаг уламжлалтай ард түмэн. Өглөө эртлэн босоод цайгаа тухтай уугаад гарахад тэр өдрийн ажил үйл бүтэмжтэй сайхан гэж ярьдаг. Манай Засгийн газар иргэд залууст эртэч байхыг амьдралын эрүүл дадал хэвшил болгон эрүүл, идэвхтэй жингийн илүүдэлгүй байхыг уриалж байгаа билээ.



3. Насжилт ба хөдөлгөөн. Идэвхтэй амьдралын хэв маяг болон насжилт нь өөр хоорондоо нягт холбоотой байдаг. Эрүүл амьдралын хэв маягийг бий болгох чухал алхам бол амралт, хөдөлгөөний тэнцвэр юм. Тиймээс тогтмол дасгал хөдөлгөөн хийж хэвших нь чухал. Энэ нь эрүүл, урт удаан наслахын үндэс болдог.

Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж, хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бий болгох юм. Ингэхдээ биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоог цогцоор нь боловсронгуй болгоно. Мөн биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийг бэлтгэх тэднийг чадавхжуулах, дэмжлэгийг нэмэгдүүлэхээр зорьж байна. Энэ нь биеийн тамир, спорт, бүх нийтийн болж дэлгэрэн хөгжих суурь боломжийг бүрдүүлэх үндэс билээ.

Идэвхтэй амьдралын дадал хэвшилтэй иргэнийг төлөвшүүлэхэд биеийн тамир, спортын чанар, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ. Хот, суурин газрын орон сууцны хороолол, хотхоны төлөвлөлтөд

Жин ба нас

Илүүдэл жинтэй хүмүүсийн дундаж наслалт хэвийн жинтэй хүмүүсээс 7-12 жилээр бага байдаг. Манай улсад 5-аас доош насны хүүхдүүдийн 10.5 хувь нь илүүдэл жинтэй байна.

Олон нийтийг хамарсан автомашингүй өдөр, бүх нийтийн марафон гүйлт зэрэг арга хэмжээ тогтмол зохион байгуулж байх нь иргэдийн санаачилгыг өдөөж буй эрүүл мэндийн арга хэмжээ юм.

биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан олон улсын стандарт шаардлагад нийцсэн тохилог, тухтай орчныг бүрдүүлэхээс эхэлсэн. Ингэснээр иргэн бүр гэрийнхээ орчимд биеийн тамир, спортоор хичээллэж, өөрийн бие бялдар, эрүүл мэндээ дэмжиж, амьдралын эрүүл хэв маяг, дадалтай болох юм. Энэ нь бага насны хүүхдүүдэд зөв үлгэр дуурайл болж, багаасаа биеийн тамир, спортоор хичээллэдэг зөв дадалтай болохоос гадна авьяас чадвараа нээж, хөгжүүлэх боломжийг бүрдүүлж буй юм. Хүүхэд залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог илүү боловсронгуй болгох нь энэ салбарын тэргүүний зорилтын нэг билээ.

Биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон төлөвшүүлэхийн тулд иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн насан туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. Энэ хүрээндээ иргэдийн бие бялдарын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг нас насны ангиллаар тогтоож мөрдүүлнэ. Үүний үр дүнд бий болсон амжилтыг бататгахын тулд иргэдийн спортын төрөлжсөн наадмыг улсын хэмжээнд дөрвөн жил тутамд зохион байгуулахаар төлөвлөөд байна.





Зураг 31. Өглөөний дасгалын ач тус

ӨГЛӨӨНИЙ ДАСГАЛЫН АЧ ТУС



- Сэрэмжтэй байдал нэмэгдэх
- Илүү их эрч хүчтэй байх
- Төвлөрөх чадвар нэмэгдэх
- Сэтгэлзүйн эерэг нөлөө нэмэгдэх
- Жингийн илүүдэлгүй байх
- Хоолны дуршлыг хянах
- Хөдөлгөөний идэвх нэмэгдэх
- Цусан дахь глюкозыг хянах
- Нойрыг сайжруулах

Үүний тулд биеийн тамир спортын тогтолцоо, санхүүжилт, хүний нөөцөд анхаарах учиртай. Энэ салбарын санхүүжилтийг гүйцэтгэлд суурилсан системд шилжүүлнэ. Хувь хүний хэрэгцээг хангасан байдал, чанартай үйлчилгээ, ахиц амжилтыг үнэлдэг болно гэсэн үг. Мөн биеийн тамир, спортын сургалт эрхэлдэг байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлийн шаардлагыг шинэчилж, чиг үүргийг нь хараат бус мэргэжлийн байгууллагад шилжүүлснээр иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн спорт клуб, заалууд олноороо бий болох боломжтой юм.

Эрүүл амьдралын хэв маягийг удирдана гэдэг нь одоо байгаа хооллох, биеийн тамирын дасгал, амралтын дадал зуршлаа бүрэн өөрчлөх явдал юм. Дасгал хөдөлгөөн бол эрүүл амьдралын хэв маягийн салшгүй нэг хэсэг. Дасгал хөдөлгөөн амьдралыг уртасгаж, эрүүл мэндийг хамгаалж, өвчинд өртөх эрсдэлийг бууруулдаг гэдгийг судалгаагаар баталсан байна. Гэвч ДЭМБ-ын судалгаагаар хүмүүсийн 60-85 хувь нь эрүүл мэнддээ ашиг тустай дасгал хөдөлгөөн хийдэггүй гэсэн дүгнэлт гарчээ. Хүн өдрийн 5-8 цагт байнга хөдөлгөөнтэй байхыг эмч нар зөвлөдөг. Ингэснээр биеийн идэвх хөдөлгөөн мэдрэмжтэй байдал сэргэж, өөртөө итгэх итгэлтэй болдог аж. Түүнээс гадна багийн спортоор хичээллэх нь мөн нийгмийн харилцаа үүсгэх боломж бүрдүүлдэг. Дасгал нь биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалдаг. Ялангуяа амьсгал, зүрх судас, булчин, үе мөчний тогтолцоонд эергээр нөлөөлдөг.

Эрүүл амьдралын хэв маягтай, дасгал хөдөлгөөн хийдэг дадал хэвшилтэй, эртгч үндэстэн болоход иргэн бүрийн оролцоо чухал.

Хувь хүн бүр дасгал хөдөлгөөний давуу талыг ойлгосон, дархлаа дэмжих арга замаа мэдсэн байх нөхцөлийг хангахын тулд эрүүл амьдралын хэв маягийг сурталчлан таниулах, бага наснаас хэвшүүлэх нь нийгэмд олон эерэг өөрчлөлт бий болгоно.

ТАМИРЧНЫ ЯЛАЛТ ХЯМДХАН ОЛДОХГҮЙ



Монгол Улсад 30 гаруй спортын холбоод үйл ажиллагаа явуулж байна. Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн технологийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн нэгдсэн бааз, платформ бий болгоно. Мөн хүүхэд, залуучуудын спортын унаган авьяасыг нээж, дэлхийн түвшний шилдэг тамирчдыг бэлтгэх, хөгжүүлж, улс үндэстнийхээ нэрийг олон улсад тунхаглан дархлах тамирчдын буухиаг тасралтгүй үргэлжүүлэх ёстой. Үүний тулд биеийн тамир, спортын нэн шаардлагатай болон тэргүүлэх чиглэл, мэргэжлээр хүний нөөц бэлтгэх, орон нутгийн хэрэгцээг хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх нь чухал юм.





ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ СПОРТ ТӨВҮҮД



Эрүүл мэндээ хайрлан хамгаалахад амьдралын зөв дадал, хэвшил чухал ач холбогдолтой. Эрүүл амьдралын зөв дадал хэвшлийг бий болгоход хот, суурин газрын орон сууцны хороолол, хотхоны төлөвлөлтөд биеийн тамир, спортоор хичээллэх, амьдралын зөв дадал хэвшилтэй болгох олон улсын стандарт шаардлагад нийцсэн тохилог, тухтай орчныг бүрдүүлэх нь чухал. Биеийн тамир, спортын сургалт эрхэлдэг байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлийн шаардлагыг шинэчилж, чиг үүргийг нь хараат бус мэргэжлийн байгууллагад шилжүүлснээр иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн спорт клуб, заалууд олноороо бий болох боломж бүрдэнэ.



АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

ГАЗРЫН ХАРИЛЦАА

ЗОРИЛТ 3.6 Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Байрлалд суурилсан орон зайн мэдээлэл бүхий ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог нэвтрүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах үе



Үл хөдлөх хөрөнгийн гурван хэмжээст кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийг бий болгоно. Ингэснээр иргэдийн үл хөдлөх эд хөрөнгө 100 хувь бүртгэлд хамрагдаж, үнэлгээ нь нэмэгдэн, баталгаат мэдээлэлд суурилсан газар, үл хөдлөх хөрөнгө, эд хөрөнгөө эдийн засгийн эргэлтэд оруулах зах зээл бүрдэх юм.

Улсын үндэс нь газар юм. Манай улс нутгийн баруунаас зүүн цэг хүртэл 2,392 км, хойноос өмнө цэг хүртэл 1,259 км, нийт 1,564.1 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай. Өргөн уудам нутагтай ч төлөвлөлт, зохион байгуулалт зайлшгүй шаардлагатай. Хүн амын нутагшил, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэд, олон нийтийн оролцоотойгоор газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн системийг бий болгох юм. Хөгжлийн урьдач нөхцөл нь газрын сайн төлөвлөлт. Газраа хэдий чинээ сайн төлөвлөнө, төдий чинээ хөгжлийн сууриа бат найдвартай тавих болно. Тиймээс газрын харилцааг цогцоор нь шийдвэрлэхээр зорилгоо тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагаануудаа тусгалаа.

Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг



Зураг 32. Газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн систем



Газрын харилцааны иргэн төвтэй удирдлага, менежментийг нэвтрүүлж, газрыг төлөвлөх, бүртгэх, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих тогтолцоо бүрдүүлэх, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл, боломжийг нэмэгдүүлэх, төрийн өмчийн газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, газрын нэгдсэн төлөвлөлт, бүртгэлээр дамжуулан салбар хоорондын уялдааг хангах юм.

Эх сурвалж: БХБЯ (2020)

дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. Ингэснээр газрын харилцаа олон нийтэд илүү нээлттэй болж, ил тод харилцаа үүсэх юм. Мөн газрын бирж, олон зориулалттай кадастрын нэгдсэн системийг нэвтрүүлж, газрын нэгдмэл сан, түүний ашиглалтад тавих төрийн хяналтын тогтолцоог улам боловсронгуй болгоно. Монгол Улсын геодезийн сүлжээг шинэчлэн байгуулж, нийт нутаг дэвсгэрийн бүх төрлийн масштабыг байр зүйн зургаар бүрэн хангах юм.

Байрлалд суурилсан орон зайн мэдээлэл бүхий ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог нэвтрүүлнэ. Газрын хяналт, удирдлагын нэгдсэн тогтолцоог бий болгон бэхжүүлж, үндэсний орон зайн мэдээллийн нэгдсэн платформыг бүтээж, хэрэглэнд хэвшүүлнэ.

Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана. Газрын удирдлага, менежментийн тогтолцоо хүртээмжтэй, ухаалаг системтэй болсон байна.

Их өгөгдөлд суурилсан "Ухаалаг, цахим газрын зураг" мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, орон зайн өгөгдлийн систем, дэд бүтцийг бий болгоно.

Их өгөгдөлд суурилсан "Ухаалаг, цахим газрын зураг" батлан хамгаалах, хот байгуулалт, барилга, газар зохион байгуулалт, геологи уул уурхай, байгаль орчин, авто болон төмөр зам, хөдөө аж ахуй салбарын үйл ажиллагаанд ашиглана.

УХААЛАГ, НЭЭЛТТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ШИЙДЭЛТЭЙ ГАЗРЫН ХАРИЛЦАА

Дэлхий нийтэд хэрэглэгдэж буй техник технологийг ашиглан газрын бүртгэл, ашиглалт, хэмжилтийг илүү оновчтой болгох шаардлага манай улсад зүй ёсоор тулгарч байна. Дэвшилтэт технологид суурилсан гурван хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн системийг хөгжүүлж, улсын хэмжээнд гурван хэмжээст байр зүйн болон газар доорх инженерийн шугам сүлжээний зургийг зохиож ашиглах нь бидний ирээдүйн хот байгуулалтын үндэс болох юм.


















Хүн амын 50 хувь нь төвлөрсөн нийслэл хотын нутаг дэвсгэрийн ихээхэн хэмжээний газар дэд бүтэцгүй байгаа байдал нь бүс нутгийн өрсөлдөх чадвар өндөртэй олон улсын томоохон хотуудтай харьцуулахад хотын хөгжлийг сулруулж байна. Зүүн Азийн бүс нутгийн 100,000-аас дээш хүн амтай 869 хотуудаас ердөө 182 (21 хувь) нь Улаанбаатар хотоос бага нягтаршилтай байна. Нягтаршил багатай хотжилт нь хувийн автомашины хэрэглээний хэрэгцээг нэмэгдүүлдэг ба энэ нь замын хөдөлгөөний түгжрэл болон зорчих хугацааг нэмэгдүүлэн, ажиллагсад, компаниудын цаг хугацаа, хөрөнгө мөнгийг зарлагаддаг.

Газрын харилцаанд оролцдог олон тооны төрийн байгууллагууд байгаа нь ажлын давхардлаас гадна газрын чиглэлээр үйлчилгээ авагч нарын хувьд илүү зардал, төөрөгдөл бий болгож байна. Иймд бүрэн цахим үйл ажиллагаатай газрын биржийг байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн системийг бий болгоно. Газрын төлбөр, ашиглалтын зардал үнэлгээг ч орчин үеийн шийдлээр зохион байгуулж, иргэдэд чирэгдэлгүй болгохоор зорьж байна. Гэрчилгээг цаасаар бус цахимаар, баганан кодоор олгож байна. Мөн кадастрын системийг ухаалаг, нэгдсэн байдлаар хөгжүүлж, иргэдэд илүү ойлгомжтой, хүртээмжтэй болгоно. Газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.

Газрын харилцаанд орчин үеийн дэвшилтэт техник технологи, хиймэл оюун ухаан, блокчейн системийг ашиглахаар төлөвлөж байна. Энэхүү ухаалаг системүүдийг ашиглан газрын үнэлгээ, төлбөр, татвар, биржийн тогтолцоог бий болгох юм. Улмаар дэвшилтэт технологид суурилан гурван хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн системийг хөгжүүлнэ. Улсын хэмжээнд гурван хэмжээст байр зүйн болон газар доорх инженерийн шугам сүлжээний газрыг зохионо. Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд



Зураг 33. Орон зайн мэдээллийн системийн өгөгдлүүд

 Газарзүйн нэр	 Газрын нэгж талбар	 Газрын бүрхэвч	 Геодезийн тулгуур сүлжээ
 Геологи	 Орто зураг	 Ус зүй	 Өндөржилт, гүн
 Хөрс	 Тээврийн сүлжээ	 Хүн ам зүй	 Дэд бүтэц
 Хаяг	 Хил зааг	 Байр зүй	 Газар ашиглалт
 Барилга, суурин газар	 Түүх, соёл, археологийн өв		

Эх сурвалж: БХБЯ, 2020

нийцсэн байр зүйн болон сэдэвчилсэн газрын зураг, атласаар хангах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Геодезийн олон улсын маш урт суурь талтай интерферометрийн станц байгуулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг нутагшуулна. Ингэснээр газрын харилцааны үр өгөөж нэмэгдэж, байгаль, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангаж чадах юм.

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний сүлжээ байгуулах ажлын хүрээнд төрийн өмчийн болоод иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтөд үзүүлэх хүний болон байгалийн хүчин зүйлсийн нөлөөллийг богино хугацааны давтамжтай тодорхойлж, түүнд тохирсон газар зохион байгуулалтын арга хэмжээг цаг алдалгүй, оновчтой авч хэрэгжүүлэх, бусад газрын харилцааны цахим системүүдтэй уялдаж ажиллах Газрын мониторингийн цахим системийг байгуулаад байна.

Орон зайн өгөгдлийн дэд бүтэц

Газрын удирдлагын цахим систем нь харилцан уялдаатай долоон системээс бүрдэнэ. Үүнд,

1. Мониторингийн нэгдсэн систем
2. Төлөвлөлтийн нэгдсэн систем
3. Газрын биржийн цахим систем
4. Газрын үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн систем
5. Кадастрын нэгдсэн систем
6. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн систем
7. Хаягийн мэдээллийн систем

ШИНЖЛЭХ УХААНД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ

Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. Хот байгуулалт, инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийг төлөвлөх, барьж байгуулах, өргөтгөх, ашиглах үеийн геодезийн хэмжилтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.

Зураг 34. Байрлалд суурилсан орон зайн мэдээлэл





ГАЗРЫН НӨӨЦИЙН ҮР ДҮНТЭЙ АШИГЛАЛТ

Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.

Зураг 35. Гурван хэмжээст кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн систем



ЭХ СУРВАЛЖ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Барилга, Хот Байгуулалтын Яам. (2021). Салбарын танилцуулга. УБ.

Биеийн тамир, спортын улсын хороо. (2022). Спортын холвоод. <https://sport.gov.mn/>

Дэлхийн эдийн засгийн форум. (2022). This chart shows the rise of the Asian Middle Class. <https://www.weforum.org/agenda/2020/07/the-rise-of-the-asian-middle-class>

Дефакто институт. (2020). Алсын хараа 2050 шүүмж, нийтлэлүүд. УБ.

Монголбанк. (2022). ЖДҮ эрхлэгчдэд олгосон зээлийн тайлан. Статистик: <https://www.mongolbank.mn/liststatistic.aspx?id=14>

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим. (2020). "Монголын бизнес орчин 2020" судалгааны тайлан. УБ.

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага. (2021). "Нийгмийн даатгал" гарын авлага. УБ.

Удирдлагын академи. (2022). "Монгол улсын хөгжлийн бодлого төлөвлөлт - Алсын хараа 2050" онлайн сургалт. <https://surgalt.gov.mn/#/landing/2146553/69964>

Үндэсний Статистикийн Хороо. (2020). Монгол Улсын хүн ам, орон сууцны тооллого. УБ.

Үндэсний Статистикийн Хороо. (2022). Ашиглалтад оруулсан үндсэн фонд. Статистик мэдээллийн нэгдсэн сан: https://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0902_009V1

Үндэсний Статистикийн Хороо. (2022). Бүтээмж. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: https://1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L25&type=tables

Үндэсний Статистикийн Хороо. (2021). Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: https://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2200_001V1

Үндэсний Статистикийн Хороо. (2022). Нэг өрхийн сарын дундаж орлого. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_1900_001V1

Үндэсний Статистикийн Хороо. (2021). Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2021 оны II улирлын танилцуулга. УБ. https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Tan_HSES_2021.2Q.pdf&ln=Mn

Хот төлөвлөлт судалгааны институт. (2021). Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө "Орон сууцны хангамж". УБ.

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам. (2021). Салбарын танилцуулга. УБ.

Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн. (2016). "Монголын дундаж давхаргын судалгаа" судалгааны ажлын урьдчилсан тайлан. УБ.

IKON.mn мэдээллийн цахим хуудас. (2018). Н.Болормаа: Илүүдэл жинтэй хүмүүсийн дундаж наслалт 7-12 жилээр бага байдаг. <https://ikon.mn/n/19ys>

Credit Suisse Research Institute. (2021). Global Wealth Databook 2021.

Government Pension Fund Global. (2022). About the fund. <https://www.nbim.no/>

Public Service Division, Prime Minister's Office. (2022). HOUSING A NATION, BUILDING A CITY. <https://www.psd.gov.sg/heartofpublicservice/our-institutions/housing-a-nation-building-a-city/>

Statista. (2022). Forecast of the global middle class population from 2015 to 2030, by region. <https://www.statista.com/statistics/255591/forecast-on-the-worldwide-middle-class-population-by-region/>

ТОВЧИЛСОН ҮГС ИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим
НДС	Нийгмийн даатгалын сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ОХУ	Оросын Холбооны Улс
УСХ	Үндэсний статистикийн хороо
ЭМЯ	Эрүүл мэндийн яам